

Карма.

Материаллаг амьдрал бол бидний анхдагч жинхэнэ төлөв байдал биш. Сүнс (жинхэнэ эго, жинхэнэ “Би”) бол цэвэр бурханлаг эрчим бөгөөд чанарын хувьд бүдүүн ч тэр, мөн нарийн ч тэр материас ялгаатай. Сүнсний зориулалт буюу дхарма бол үйлчлэн зүтгэх явдал. Анхдагч жинхэнэ төлөв байдалдаа бол бие даасан сүнс эрчмээ үйлчлэл зүтгэлийн мөнхийн объект Дээд Сүнс буюу Дээдийн дээд Бодьгалд зориулдаг.

Ухамсрын гажуудсан төлөв байдалд орсон сүнс алдагдсан, гээгдэж цөхөрсөн байдалтай болдог бөгөөд түүний бүхий л эрчим нь сүнсний материаллаг төсөөллийн биелэл— хуурамч эгоны эрхшээл захиргаанд ордог. Шримад Бхагаватамын (11.28.15)-д: “Уй гашуу уйтгар гуниг, баяр хөөр, уур хилэн, хомхойрол шунахайрал, төөрөгдөл эндүүрэл болон шунаг сувдаг хүслүүд, мөн тэрчлэн төрөлт болон үхэл— энэ бүгдийг цэвэр ариун сүнс биш, харин хуурамч эго л амсаж эдэлж, тэсэж туулдаг.” Өөрийгөө материтай эндүүгээр адилтгасан энэхүү жам ёсны бус төлөв байдалд сүнсний эрчим нь материаллаг мөн чанарын гурван гунуудын янз бүрийн байдлаар зохицон нийцэж холилдсон холилдоон сүлжилдээний бүхий л, олон янз бүхий хий хуурмаг байдалд үйлчлэн зүтгэхэд үрэгдэн шамшигддаг.

Сүнсний энерги буюу эрчим гэж юу вэ? Сүнс бол бодьгал. Тодорхойлолтоор бол, мэдрэхүйтэй хийгээд шийдвэр гаргах чадвартай амьд оршнолыг бодьгал гэдэг. Шийдвэр гаргах болон мэдрэхүйтэй байх гэсэн энэ хоёр зүйл нь сүнсний үндсэн хоёр эрчмийг тодорхойлдог. Шийдвэр гаргах гэдэг нь мэдлэгийн эрчмийг, харин мэдрэхүйтэй байна гэдэг нь цэнгэл жаргалын эрчмийг заадаг. “Би бол мэдэх, ойлгох чадвартай.” болон “Би бол цэнгэн жаргаж, хайрлаж чаддаг.” гэдгээ хэн бүр ойлгодог.

Эдгээр эрчмүүд нь, тэдгээрийг юугаар ч хязгаарлаж, арилгаж үгүй болгох боломжгүй гэдэг утгаараа үндсэн эрчмүүд юм. Эдгээр эрчмүүд нь итгэл бишрэл зэрэг сэтгэл зүйн олон ойлголтуудыг тодорхойлох болон сэтгэл зүйн үзэгдлүүд хийгээд феномен (онцгой гойд зүйл)-г гүн гүнзгий ойлгоход туслах эхлэлийн цэг нь болж өгдөг.

Эдгээр хоёр эрчим нь хуурамч эго-гоор нэвтрэн гарснаар гажуудсан хэлбэртэй болдог: 1) Цэнгэл жаргалын эрчим нь бүдүүн түвшний буюу бие махбодийн таашаал ханамж эдлэх болон нэр цуутай болох, алдар хүндэтгэлд хүрэх, бусдаас ялгарч товойн гарах гэх мэтийн нарийн түвшний эрмэлзэл гэсэн хэлбэртэй хүсэл тачаал, шунахайрал хомхойрол болон хувирдаг.

2) Мэдлэгийн эрчим нь материаллаг ертөнцийг таньж мэдэх болон ийнхүү таньж мэдсэнээр түүнийг эзэмшин захирах гэсэн эрмэлзэл болж өөрчлөгддөг. Энэ бол мэдлэгийн тусламжтайгаар материаллаг мөн чанарыг буюу байгалийг эрхшээлдээ оруулах гэсэн шунал юм.

Цэвэр ариун сүнсэнд мэдлэгийн болон цэнгэл жаргалын гэсэн энэ хоёр эрчим мөн л угийн байж байдаг. Гэхдээ түүнд байдаг эдгээр эрчим нь үл ялих буюу хязгаарлагдмал хэмжээтэй болно. Харин Кришнад бол тэдгээр эрчмүүд хэмжээлшгүй хязгааргүй их хэмжээтэй байх бөгөөд байнгад өсөн нэмэгдэж байдаг.

Сүнс өөрийн танин мэдэхүйн (Бурханыг таньж мэдэхийг эрмэлзэн байгаа) болон цэнгэл жаргалын (Бурханы мэдрэхүйд хайр дүүрэн үйлчлэн зүтгэхийг эрмэлзэн байгаа) үл ялих өчүүхэн бага чадвараа Кришнад зориулах аваас Тэрээр ийм сүнснийг мэдлэг болон цэнгэл жаргалын Өөрийн хэмжээ хязгааргүй эрчмээрээ дүүргэн бялхаадаг. Ингэснээр сүнс цэнгэл жаргалын болоод ойлголт ухаарлын далайд умбадаг. Бидний зориулалт бол энэхүү далайд сэлэн умбах явдал. Ийн умбаж байгаа төлөв байдлыг Бурханыг хайрлах хайр гэж нэрлэдэг. Санскритаар бол кришна-према-бхакти. Энэ бол бидний амьдралын жинхэнэ зорилго.

Кармын үндсэн үзэл баримтлал.

Карма гэдэг үгийн ерөнхий утга бол “үйл ажиллагаа”, “үйлдэл”, “үйл” эсвэл “ажил хөдөлмөр”. Карма гэдэг үг нь кри буюу “бүтээх, үр дагаврыг бий болгох” гэсэн утга бүхий санскрит үндэснээс гаралтай. Өөрөөр хэлбэл, карма нь тодорхой үр дүн, үр дагаварт хүргэдэг үйл.

Амьд оршнол материаллаг ухамсартай байгаа цагтаа материаллаг бие махбодид орон материаллаг ертөнцөд үйл хөдлөл хийдэг. Эдгээр үйл нь оршин байгаа тухайн бие махбодийн нь амьдралын үргэлжлэх хугацааны дотор боловсорч гүйцэн илэрч гарахааргүй тийм үр дагавруудыг ч бий болгодог. Иймэрхүү төрлийн үр дагаврууд нь хуримтлагдсаар амьд оршнолын ирээдүйн амьдралуудынхаа аль нэгэнд авах шинэ бие махбодийн хувь тавилангийн үзүүлэлтүүдийг тодорхойлж хэлбэржүүлэн бий болгодог. Ийнхүү сүнс одоогийн энэхүү бие махбодидоо оршин байхдаа өөртөө зориулан ирээдүйд аван төрөх шинэ бие махбодио аажмаар бий болгодог хэрэг. Үүнийг карма гэж нэрлэдэг. Карма бол

материаллаг ухамсрынхаа хүчээр материаллаг шинэ бие махбодио аажмаар бүтээж бий болгох явдал юм. Ийм амьд оршнол хуучин бие махбодио үхсэний дараагаар шинэ бие махбодид шилжин ордог.

Кармендрийа.

Энд бид “карма” гэдэг нэр томъёог зөвхөн, материаллаг бие махбодийг аван төрсөн амьд оршнолуудтай холбоотойгоор авч үзэх болно. Материаллаг эрчим бидэнд 1) ам (ярих, идэх гэсэн хоёр үүрэг бүхий), 2) гар, 3) хөл, 4) генитал болон 5) анус буюу шулуун гэдэс гэсэн үйлийн таван эрхтэн бүхий бие махбодийг өгдөг. Мэдрэхүйн эдгээр эрхтэнгүүдийг мэдрэхүйн үйлийн буюу ажлын эрхтэнгүүд гэж нэрлэдэг (Санскритаар кармендрийа гэдэг.).

Амьдралын доод түвшний хэлбэрүүдэд эдгээр эрхтэнгүүд мөн л байдаг, гэхдээ тэдгээр нь хүнийхтэй харьцуулахад танигдахын аргагүй өөр, ялгаатай. Энэ тохиолдолд бид тэдгээрийг доорхи байдлаар тодорхойлж болно:

—Хоол тэжээл идэх эрхтэн

—Өөрийгөө хамгаалах болон олз олбор олох эрхтэн

—Явах, хөдлөх эрхтэн

—Үржлийн эрхтэн

—Бие махбодиос ялгадас гадагшлуулах эрхтэн

Адгуусан амьтад ер нь бол дөрвөн хөл дээрээ явдаг бөгөөд урд хөлүүд нь мөн тэдний “гарын” үүргийг гүйцэтгэх нь олонтаа. Гэхдээ үүнийгээ зөвхөн урд хөлөөрөө биш, мөн хойд хөлөөрөө гүйцэтгэх тийм хангалттай чадварыг хөгжүүлсэн байх нь ч бий. Тухайлбал, сүүлнийхээ тусламжтайгаар модноос дүүжлэгдэн байгаа үед тэдний хувьд сүүл нь хөлийнх нь үүргийг гүйцэтгэдэг. Зааны хувьд хошуу нь түүний гарын үүргийг гүйцэтгэдэг. Модны хувьд хоол тэжээлээ авах буюу идэх хооллох эрхтэн нь түүний үндэс. Бактер болон микробуудын хувьд энэ болгоныг нэг эрхтэн буюу мембран гүйцэтгэдэг хэдий ч энэ бүх үүргүүд мөн л бүгдээрээ байдаг.

Бурханлаг сүнс бүрт үйлийн таван мэдрэхүй угийн байдаг. Амьд оршнол өөрийгөө материтай адилтган үзэж эхэлмэгц хуурамч эго түүнээс бүхий л эрчмийг нь, түүний дотор мөн мэдрэхүйг нь сорон аваад материт оруулж шингээн түүнийг амилуулдаг. Эдгээр мэдрэхүйнүүдийн хүний бие махбодид илэрч тодорч байгаа байдал нь тэдгээрийн анхдагч жинхэнэ бурханлаг байдалдаа ямархуу байдагтай онцгой ойр дөхөм.

Кармын хоёр үндсэн тодорхойлолт.

Карма гэдэг үг олон утгатай. Энэ үг хэд хэдэн үндсэн гол утга санааг илэрхийлдэг боловч бид тэдгээрээс зөвхөн хоёр үндсэн голыг нь авч үзэх болно. Бусад утгууд нь бидний авч үзэж буй хүрээнээс халин гарсан асуудлуудтай холбогдох учраас тэднийг авч үзэлгүй орхих болно.

Карма гэдэг үгийн эхний утга бол бие махбодийг аван төрсөн амьд оршнолын үйлийн таван эрхтэнгүүдийнхээ (кармендрийа) тусламжтайгаар хийж үйлдэж байгаа үйл ажиллагаа, үйл буюу ажил хөдөлмөр юм. Энэ үйлийн нийлбэр үр дүн нь карма гэдэг үгийн хоёр дахь утга болно. Үүнийг мөн адил төстэй утгаар “үйлийн үр дагавар”, “кармын хариу үйлдэл” эсвэл зүгээр л “хувь заяа, тавилан” гэж нэрлэдэг.

Хүн амьдралынхаа туршид үйл ажиллагаагаа янз бүрийн гунууд дахь сэдэл шалтгааныг удирдлага болгох хийгээд үйл ажиллагаагаа янз бүрийн гунуудад эрхэлж явуулснаар олон янзын үйлүүд үйлддэг. Амьдралын эцэст, төгсгөлд үр дагавруудын нийлбэр дүн тооцоологдож, бодогдож амьд оршнол дараагийн төрөлтдөө шилжин ордог. Кармын үр дагаврынх нь ихэнх нь цэвэр ариунд оногдож байх аваас сүнс хүнээс илүү дээд оршнол болж дээд гаригууд дээр төрдөг. Нийлбэр дүнгийн ихэнх нь хүсэл тачаалд оногдож байх аваас дунд түвшний гаригууд дээр хүн байдлаар, харин харанхуй мунхагт оногдож байх аваас адгуус амьтан болж эсвэл түүнээс доошхи төрлийг авдаг.

Тахилга өргөл болон оноогдсон үүргүүдээ цэвэр ариуны гунад биелүүлж байх нь хүний кармыг сайжруулдаг гэж Ведэд заадаг. Тахилга өргөлийн бүхий л хэлбэр төрлийн оргил нь буюу дээд цэг нь зөвхөн л, Бүхний Дээд Бурханд чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа байдаг. Ийм үйл ажиллагааг трансценденталь карма буюу наишкарма гэж нэрлэдэг. Ийм үйл ажиллагаанд өөрийгөө зориулж байгаа сүнс төрөлт үхлийн эргэлдэх хүрднээс бүрнээ мултран ангижирч чадна. Тэгэхлээр, кармын сэдэв нь дахин төрөлт болон ангижралын сэдэвтэй нягт холбоотой.

Дээд Сүнсний үүрэг роль.

Дээд Сүнс бол Бурханы Бодьгалын хувилгаан дэлгэрэл дүр бөгөөд амьд оршнол бүрийн зүрхэнд болон орчлонгийн атом бүрт залран байдаг. Дээд Сүнс бол бие даасан сүнсний удирдлага болгож буй

сэдэл шалтгаан болон түүний бүхий л хүсэл болоод үйлүүдийн гол гэрч. Бхагавад Гитагийн (13.23)-д батлан өгүүлсэнчлэн, Дээд Сүнс ажиглах болон зөвшөөрөх (буюу бидэнд бол өөгшүүлэх гэсэн утгаар санагдаж байж болох) гэсэн хоёр үүргийг гүйцэтгэдэг. Дээд Сүнс гэрч болж байгаа үйл (буюу карма) нь кармын үр дагавар хэлбэртэйгээр материаллаг эрчмийн тусламжтайгаар нэг бол урамшуулагддаг эсвэл шийтгүүлдэг. Дээд Сүнс бүгдэд огтын алагчлалгүйгээр, бүрнээ шудрага ханддаг. Бурханы Бодьгалын хувилгаан дэлгэрэл болохын хувьд Тэрээр энэ ертөнцөөс юу ч үл хүсдэг. Түүнд хэнээс ч, юу ч хэрэггүй. Дээд Сүнсний хийж үйлдэж байгаа бүхэн хэнд ч, эсвэл юунд ч татагдах болон үл татагдахын нөлөөн дор оролгүйгээр болзолдож нөхцөлдсөн сүнсэнд үйлчлэх явдал. Иймээс Дээд Сүнс бол ямар ч өө сэвгүй, шудрага.

Сонголт хийх хязгаарлагдмал эрх чөлөө.

Сонголт хийх боломж бол бидэнд үргэлж байдаг. Бид үйлдэх үйлээ эрх чөлөөтэйгөөр сонгодог, гэхдээ харин үр дагаврыг нь сонгох эрх чөлөө бол байхгүй. Үйлийн үр дагаврууд нь өөрийн ээлжиндээ үйлийг сонгох, тэдгээрийг сужах, эсвэл тэр хэвээр нь орхих бидний боломжийг өргөжүүлдэг.

Бурханлаг ертөнцөд л сүнс хамгийн өргөн сонголтыг хийх боломжтой байдаг. Энэхүү сонголт хүслийн хоёр төрлөөс бүрддэг. Хүслийн эхний ангилал— энэ бол Бурханы Бодьгалд үйлчлэн зүтгэх хүсэл. Энэ ангилалд тоо томшгүй олон янзын хувилбарууд багтдаг. Хоёр дахь ангилалд материаллаг ертөнцөд очин тэнд аз жаргалыг эдлэхээр Кришнагаас салан холдох гэсэн хүсэл хамаарагддаг.

Бүхний Дээд Бурханд үйлчлэн зүтгэхийг хүсэж байгаа цагтаа амьд оршнол бурханлаг ертөнцөд оршсон хэвээр байх бөгөөд үйлчлэн зүтгэх гэсэн түүний сонголт үргэлжид хувиршгүй, хэмжээ хязгааргүй хэвээр байдаг. Үйлүүд нь уяж хүлэн цаашдын үйл ажиллагааг бий болгох тийм үр дагавруудыг дагуулдаггүй, авчирдаггүй. Энэ бол жинхэнэ эрх чөлөө.

Харин материаллаг ертөнц дэх бидний сонголт хийх эрх чөлөө өнгөрсөн үйл ажиллагаануудын үр дагавраас болж хязгаарлагдмал байдалтай болдог. Заримдаа хүн өөрийн “тоглож буй тухайн дүр” буюу оршин байгаа бие махбодиосоо хамаараад урам хугардаг, тэр бүү хэл ичих болон уурлаж бухимдах ч явдал гардаг. Гэхдээ л түүнд өөр сонголт байдаггүй, тэрээр өөрийн байхыг хүсэж байгаа тийм байдлаараа байж чаддаггүй.

Болзолдож нөхцөлдсөн сүнсний тодорхойлолт.

Шрила Прабхупадагийн номуудад “болзолдож нөхцөлдсөн сүнс” гэдэг үг олонтаа тааралддаг. Энэ ойлголт чухам юу гэсэн утгатай үг болохыг тодорхойлох нь чухал.

“Өөрөө л цэнгэн жаргах гэсэн төгс төгөлдөр бус хүслээсээ болоод материаллаг нөхцөл байдлаас хамааралтай болчихсон байгаа бурханлаг сүнсийг болзолдож нөхцөлдсөн сүнс гэж нэрлэдэг.”

Цэвэр бурханлаг сүнсэнд аз жаргалтай байхын тулд ямар ч материаллаг нөхцөл огтын хэрэггүй. Материаллаг дурлан татагдлаасаа салж ангижирснаар сүнс энэхүү материаллаг ертөнцөөс бурханлаг ертөнц рүүгээ буцаж харьдаг.

Сүнс өөрийгөө аз жаргалтай байлгахын төлөөнөө материаллаг нөхцлүүдийг хэдийчинээн ихээр хүсэж хэрэглэж байна, төдийчинээн ихээр болзолдож нөхцөлддөг. Болзолдож нөхцөлдсөн байдлын их эсвэл бага гэдэг нь сүнсний өөртөө бий болгож байгаа хүслүүдээс хамаардаг. “Хүсэл бол амьд оршнолын болзолдож нөхцөлдсөн байдлын нарийн хэлбэр.” гэж Бхагавад Гитагийн (5.15)-ын тайлбарт өгүүлдэг. Материаллаг болзолдож нөхцөлдсөн байдлын олон хэлбэрүүд байдаг: Тухайлбал, хүйс, нас, яс үндэс, мэргэжил, нийгмийн бүлэг гэх мэт болон өөр бусад. Тэр бүү хэл, хүн ч гэсэн болзолдож нөхцөлдсөн байдлын мөн л нэг хэлбэр. Эдгээр материаллаг нөхцлүүдийн олныг нь бид өөрчлөх чадваргүй. Тэр бүү хэл хичээж чармайгаад ч тэр. Иймд матери бол сүнсийг амьдралын олон орчин, хүрээгээр боож хязгаарладаг.

Харанхуй мунхаг дахь хувь заяаны тухай төсөөлөл.

Тэгвэл, бидэнд ямар нэгэн эрх чөлөө гэж ер нь байдаг юм уу? Бидний сэтгэл зоригийн чөлөөт сонголтын илрэл болох үйлүүд эь угийн урьдаас тогтоогдчихсон, тодорхойлогдчихсон байдаг гэж үү? гэж асууж байж болно. Хэн ингэж урьдаас тогтоож тодорхойлдог юм бэ? Дээд хүч, Дээд Сүнс.

Гэхдээ Дээд Сүнс бүгдийг ийнхүү урьдаас тодорхойлчихдог байх аваас бие даасан сүнс ямар ч хариуцлага үүрэхгүй. Тэрээр өөрөө юуг ч шийдэхгүй байх учраас юунд ч буруудахгүй, хэрвээ шийдэх аваас, түүний бүхий л шийдвэр нь мөн л хэдийнээ урьдаас тодорхойлогдчихсон байх учраас жинхэнэ шийдвэр биш байх болно. Хэрвээ ийм байдаг юм бол энэ ертөнцөд болж байгаа муу муухай бүхний хариуцлагыг хэн үүрдэг юм бэ? Бурхан. Тэгвэл Бурхан бол хувь заяа муутай, золгүй сүнснүүдийг зовлон шаналалд нэрвэгдүүлж байдаг бүхнээс хүчирхэг, харгис хэрцгий тамлагч зовоогч болж таарах

нь ээ. Та үүнд итгэж байна уу?

Гэхдээ хоёр асуулт гарч байж болно: “Ийм бодлыг та хаанаас авч байна? Тэгвэл амьдралд ямар учир утга байна вэ?” Эдгээр асуултанд хариулах нь төвөггүй, хялбархан: 1) Бид үүнийг өөрсдийн ухаанаасаа л авсан. 2) Амьдралд ямар ч утга учир байхгүй. Иймээс хувь заяандаа л гомдоллох болон харамсан гашуудаж гаслан шаналахаас өөр юу ч бидэнд үлдэхгүй. Учир шалтгаангүйгээр гаслан шаналах нь харанхуй мунхагийн гунын шинж чанар. Ийм хүмүүсийг фаталистууд гэж нэрлэдэг.

Хүсэл тачаал дахь эрх чөлөөний тухай ойлголт төсөөлөл

Хувь заяа буюу карма зэрэг ийм зүйлс огт байдаггүй гэж хэлж ярьдаг хүмүүс байдаг. Америкийн кино болон видео бүтээгдэхүүнүүдэд дүрслэн үзүүлдэг дэлхий дээр байж болохын аргагүй хүнд бэрх гадаад нөхцөл байдлуудыг даван туулж буй хүний дүр орчин үед хүмүүсийн дур сонирхлыг онцгой ихээр татаж, маш ихээр алдаршиж байна. Гэхдээ Шрила Прабхупада ийн өгүүлдэг: “Демонууд мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэх явдал бол амьдралын дээдийн дээд зорилго гэсэн бодлыг даган баримталдаг бөгөөд энэ төсөөллөө үхэн үхтлээ хадгалсаар явдаг. Үхлийн дараа амьдрал байдаг гэдэгт ч тэр, амьд оршнол өөрийн кармагаас буюу энэ ертөнц дэх үйлээсээ хамаараад янз бүрийн бие махбодийг авдаг гэдэгт ч тэр тэд итгэдэггүй. Ар араас нь угсруулан боловсруулах тэдний амьдралын төлөвлөгөөнүүд дуусч төгсөнө гэж хэзээ ч байдаггүй. Би иймэрхүү демонлог ухаан бодол бүхий нэгэн хүнийг таньдаг байсан ба тэрээр үхэл нь ирчихээд байсан үед, дуусгаж амжаагүй байсан гэх төлөвлөгөөнүүдээ биелүүлж хэрэгжүүлэхийн тулд амьдралыг нь цааш дөрвөн жилээр уртасгаж өгөхийг эмчээс гуйж байсан. Эмч амьдрах хугацааг нь тэр бүү хэл агшин зурын төдий хэмжээгээр ч гэсэн уртасгаж сунгаж чадахгүй гэдгийг иймэрхүү тэнэгүүд мэддэггүй. Цаг нь буюу ээлж нь ирсэн л бол хүн юу хүсэж байна гэдгийг хэрэгсэж үздэггүй. Тогтоогдсон хугацаанаас секундын төдий ч гэсэн илүүтэйгээр амьдралыг таашаахыг байгалийн хуулиуд зөвшөөрдөггүй. Демонлог хүмүүс өөрийн хүч чадалд л итгэхээс биш өөрийнх нь хүрч, гаргаж байгаа бүхий л амжилтууд түүний өнгөрсөн үедээ үйлдсэн сайн үйлүүдийн нь хариу, үр шим гэдгийг бол мэддэггүй. Энэ бүхэнд хүрэх боломж түүнд олгогдсон болохоос биш, тэр үүнд өөрийнхөө хүчээр хүрсэн юм биш. Гэвч энэхүү боломжийг өгч олгож байгаа учир шалтгаануудын талаар ямар ч ойлголт түүнд байдаггүй. Энэ бүх эд баялаг бол өөрийнх нь хүч чармайлт, хичээл зүтгэлийн үр дүн гэж тэр үздэг. Демонууд өөрсдийн үйл ажиллагааны хүчинд л итгэхээс биш, кармын хуульд бол үгүй. Энэ хуулийн дагуу бол хүн өндөр дээд гарал язгуур, байр суурьтай гэр бүлд төрөх, маш баян, маш өндөр боловсролтой, эсвэл маш гоо үзэсгэлэнтэй байх явдал нь түүний өнгөрсөн амьдралдаа хийж үйлдсэн сайн үйлүүдийн нь хариу, үр дүн юм. Тэгэхэд демонлог шинжтэй хүмүүс, энэ бүх зүйлс тохиолдлын чанартайгаар хийгээд өөрсдийнх нь шинж чанарын ачаар л болж явагддаг хэмээн боддог. Хүмүүс янз бүрийн байдалтай байх, тэдний гоо үзэсгэлэн, боловсрол гэх мэт болон өөр бусад зүйлс нь урьдаас тогтоогдчихсон, тийм байхаар хэдийнээ тодорхойлогдчихсон байдаг гэдгийг тэд мэддэггүй.”

Тууштай фатализм ч бай, хувь заяаныхаа төлөө хийх тууштай тэмцэл ч бай ялгаагүй бодит байдлын талаарх үнэн зөв төсөөлөл болдоггүй. Жинхэнэ үнэн бодитой ойлголтыг Ведэд өгдөг: карма болон болзолдож нөхцөлдсөн байдлын зэрэгцээгээр сонголт хийх эрх чөлөө үргэлжид байдаг.

Нэгэн зэрэг хослон нийлэх.

Хэдийнээ оноогоод хүртээсэн буюу өөрөөр хэлбэл урьдаас тогтоогдчихсон, тодорхойлогдчихсон аз жаргал болон зовлон бэрхшээлийн зэрэгцээ урьдаас тодорхойлогдоогүй шинэ үйлүүдийг үйлдэх боломж бидэнд үргэлж байсаар байдаг. Баладева Видйабхушана Веданта-сйамантака (6 дугаар бүлэг, Карма-таттва-нирупанах)-д бичсэнчлэн, эдгээр шинэ үйлүүд нь:

1. Шууд илрэн тодордог, эсвэл бараг шууд буюу энэ амьдралын хугацаанд илрэн тодордог.
2. Энэ амьдралын дараа, ирээдүйн хойчийн амьдралд илрэн тодрох гэсэн хоёр төрлийн үр дагаврыг авчирдаг.

Эхний хэлбэрийн үр дагавар нь хуримтлагдаж хураагдсаар цаг нь болохоор өнгөрсөн амьдралын нь үйлийн үр дагавруудтай холилдон нийлж хамтдаа илрэн тодорч байж болно. Өнгөрсөн амьдралын үйлийн үр дагаврууд нь ийнхүү халхлагдан далдлагдсанаар, бүх зүйлс зөвхөн одоогийн үйлүүдээс хамаардаг гэсэн сэтгэгдэл хүмүүст төрж, бий болж байж болох. Гэхдээ ийм төсөөлөл нь мөн чанарын хувьд демонлог юм (Б.-г., 16.16-гийн тайлбар, эхний хэсэг).

Хүн одоогийн энэ амьдралаа сайжруулж, дээшлүүлж болдог юм болов уу?

Тэгж болдог нь эргэлзээгүй хэрэг. Шримад Бхагаватамын 2.10.32-ын тайлбарт ийн өгүүлдэг: “...оюун бол тухайн байр байдлыг гүн гүнзгийгээр шүүн үзэж бодох болон бүхнийг сайн тал руу нь өөрчлөх чадвартай.” Ач тустай, тааламжтай сайн хариу үр дагаврыг удаж төдөлгөйгээр шууд авчрах

тийм үйлүүдийг одоо үйлдэх аваас хүн амьдралаа сайжруулж чадна. Гэхдээ ингэж буй хүн материалист хэвээрээ үлдэх аваас өнгөрсөн амьдралдаа хийж үйлдсэн үйлүүдийн нь үр дагавар түүнийг одоо юу хийж үйлдэж байгаагаас нь үл хамааран тэртэй тэргүй л “бүрэн хэмжээгээрээ буюу бүрэн хөтөлбөрөөрөө” нөмрөн авах болно. Эдгээр хоёр хэлбэрийн үр дагаврууд нь өөр хоорондоо янз бүрийн хувь хэмжээтэйгээр холилдон нийлцгээх бөгөөд бид үүнийг бүдүүн тойм байдлаар дараахь дөрвөн хувилбарт хувааж болно:

1. Хувь тавилангаар оноогдсон муу үр дагавар + одоогийн муу үйл (болон муу шинэ үр дагавар).
2. Хувь тавилангаар нь ирж байгаа муу үр дагавар + одоогийн сайн үйл (болон шинэ сайн үр дагавар). Энэ бол гэм нүглээ наманчлахуйн хувилбар (прайашчитта).
3. Хувь тавилангаар ирж байгаа сайн үр дагавар + одоогийн муу үйл (болон шинэ муу үр дагавар). Энэ бол “Үл бүтэх этгээдүүд яагаад ингэж цэцэглэн хөгжиж, сайн сайхан байгаад байдаг юм бэ? Бурхан тэднийг харахгүй, өөр хаашаа хардаг байнаа?” гэдэг асуултын хариу.
4. Хувь тавилангаар нь ирж байгаа сайн үр дагавар + одоогийн сайн үйл (болон шинэ сайн үр дагавар).

Дээр дурьдсан хувилбаруудаас хоёр дахь нь “карма-г саармагжуулахуй” гэж нэрлэгддэг. Прайашчитта буюу гэм нүглээ наманчлах тал дээр зааж зөвлөсөн зан үйлүүдийг үйлдсэнээр хүн хувь тавилангаар нь ирж байгаа муу үр дагаврууд дээрээ “шинэ” сайн үр дагавруудыг нэмдэг. Ингэснээр муу үр дагаврынхаа заримыг саармагжуулдаг. Тэрээр “хувь заяаны цохилт” буюу өнгөрсөн үеэс ирж байгаа сөрөг муу үр дагаврыг саяхан үйлдсэн наманчлалынхаа үр дүнд өөрт нь ирж байгаа эерэг үр дагаврын тусламжтайгаар тосон хүлээж авдаг. Гэхдээ бүрэн хэмжээгээр биш ч гэсэн саармагжилт болж явагддаг бөгөөд энэ үед амьдрал аз жаргал болон зовлон шаналалын холимог болон хувирдаг. Гэсэн ч энэ нь дан ганц, ямар ч горьдлого найдлагагүй зовлон шаналалд нэрвэгдэж байснаас л дээр билээ.

Сонголт хийх эрх чөлөөт байдлын шинж тэмдгүүд.

Амьдралын үйл явцаа захирч хянаж огт чаддаггүй гэдгээ олон хүмүүс мэдэрдэг, мэддэг. Хүнд хэцүү хувь заяаныхаа талаар болон хэн нэгэн нь өөрсдийнх нь өмнөөс бүгдийг хэдийнээ (илэрхий сайн бусаар) шийдвэрлэчихэж, тэгээд л зовж шаналж байна хэмээн тэд гутранги байдлаар боддог. Гэхдээ тэдэнд илэрч байгаа энэхүү гуниг гутрал нь сонголт хийх эрх чөлөө угийн байдаг гэдгийн шинж тэмдэг юм. Сүнсэнд сонголт хийх эрх чөлөө угийн байдаггүй байсан бол хувь заяа нь түүнд саад төвөг учруулж байна гэсэн ийм мэдрэмж хаанаас гарах гарах билээ? Үүнд ийнхүү урам хугарч байгаа явдал нь түүнд байсан сонголт хийх эрх чөлөөнөөс нь үлдсэн байгаа тэр хэсэг, хэрчим нь юм. Энэхүү ханамжтай бус байдал, сонголт хийх эрх чөлөөний энэхүү хэсэгхэн хэрчим нь сүнс бол бие махбодьдоо хэзээ ч уусан нэгддэггүй гэдгийг зааж байгаа хэрэг. Хэдийгээр сүнс бүх эрчмээ энэхүү бие махбодьдоо “цутган оруулсан” хийгээд өөрийгөө түүнтэй адилтгадаг ч гэсэн хэзээ ч бүрнээ бие махбодь болдоггүй. Сүнс энэхүү бие махбодийн үйлдэж байгаа сайн эсвэл муу аль ч үйлийг үйлдэгч хэзээ ч бүрнээ болдоггүй. Заримдаа хүмүүс “Үүнийг үйлдэж байхдаа би өөрөө биш байсан байна, би өөрөөрөө байгаагүй.” гэж ярьдаг. Үнэн хэрэгтээ, тэд “Би бол энэ бие махбодь биш байсан байна.” гэж хэлж байгаа хэрэг. Би бол бие махбодь биш, би бол матери биш гэдгийг хэдийгээр маш богино хугацаанд гялсхийх байдлаар ч гэсэн тод томруунаар ойлгох явдал бол огоорохуй тийш хандсан эхний алхам юм.

Сонголт хийх нь юунд хүргэдэг вэ?

Буянтай сайн эсвэл нүгэлтэй муу үйл үйлдэх үү гэдгийн хооронд хийх сонголт хүнд үргэлж байдаг. Буянтай сайн үйл нь ирээдүйд эдлэх таашаал ханамжийн үрийг авчирдаг бол нүгэлтэй муу үйл нь зовлон шаналалын үрийг араасаа дагуулдаг. Буянтай сайн үйл (пунья-карма) бол Ведэд зөвлөсөн байдаг тухайлбал, тахилга өргөл өргөх, тэвчил хатамжлал хийх эсвэл өглөг өгөх зэрэг хэлбэрийн үйлүүд. Зарим төрлийн үйл ажиллагаанууд хэн бүгдийн хувьд адилхан байдаг буюу хийж үйлдэхийг бүгдэд зөвлөмж болгодог. Тэгвэл тодорхой хүмүүст зориулсан эсвэл тусгай нөхцөл байдалд хийж үйлдэхийг зөвлөсөн буюу үүрэг болгосон өөр үйлүүд ч байдаг. “Хэн нэгэнд нь рашаан болж байгаа зүйл бусдад нь хор болж болно.” гэсэн үг байдаг.

Нүгэлт үйл (викарма, папа-карма эсвэл угра-карма) гэж ариун гэгээн бичээсүүдэд буюу шаструудад хориглосон тийм үйлүүдийг хэлдэг.

Бүр илүү өргөн сонголт бол материаллаг мөн чанарын гурван гунуудтай харьцах харьцааны сонголт юм. Цэвэр ариуны гунатай харьцах харьцааг сонгож буй хүн дэвжин дээшилдэг, хүсэл тачаалын гунатай харьцах харьцааг сонгож буй хүн байран дээрээ л дэвхцсэн байдалтай байдаг. Харин харанхуй мунхагийн гунатай харьцах харьцааг сонгож байгаа буюу энэ гунын нөлөөнд оршин байгаа хүн уналт

доройтолд ордог.

Эцсийн дүндээ, хүний амьдралдаа хийж байгаа хамгийн гол чухал сонголт бол үйлчлэл зүтгэлийн болон бишрэл хүндэтгэлийн объектоо буюу шүтээнээ сонгох явдал. Үйлчлэл зүтгэлийн мөнхийн объект буюу Шүтээн бол Дээдийн дээд Бодьгал. Миний өмнө тулгарч байгаа гол сонголт бол би Түүнд үйлчлэн зүтгэхийг зөвшөөрөх үү эсвэл үгүй юу гэдэгт оршдог. Хэрвээ үгүй гэх аваас би өөрийн мэдрэхүйдээ болон хуурамч “Би”-дээ л үйлчлэн зүтгэх болно. Иймд, сонголт хийх боломж хүнд үргэлжид байдаг болно.

Сонголт хийх эрх чөлөөг өргөжүүлэх түлхүүр.

Сонголт хийх эрх чөлөө болон сэтгэл зоригийн хүч. Энэ хоёр ойлголт нь нягт уялдаа холбоотой. Сонгосон зорилгодоо хүрэхэд саад болж байгаа хүндрэл бэрхшээлийг туулахад хүнд сэтгэлийн зориг хэрэгтэй. Сэтгэлийн эр зориг, хат муутай хүмүүсийн хувьд бодохын ч аргагүй тийм зүйл сэтгэлийн илүү их хат, зоригтой буюу сэтгэлийн тэнхээтэй хүний хувьд хүрэх бүрнээ боломжтой байдаг. Иймээс сонголт хийх эрх чөлөө нь сэтгэлийн хүч зориг, сэтгэлийн хат тэнхээ ихийн ачаар улам бүр өргөжин тэлдэг. Сэтгэлийн хат тэнхээ буюу сэтгэлийн хүч зориг хүн бүрт байдаг. Өөр бусад аливаа хүчний адилаар бид түүнийг тодорхой хүрээ хязгаарын дотор сулруулж эсвэл хүчтэй болгож болно. Мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхээс огоорох явдлыг хөгжүүлснээр хүн сэтгэлийн хат тэнхээгээ буюу сэтгэлийн хүч зоригуу хүчирхэгжүүлэн, амьдралаа удирдан залах бүр илүү их боломжтой болдог. Харин мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхэд дурлан татагдах явдлыг хөгжүүлснээр хүн сэтгэлийн хүчээ сульдүүлж, хяналтаа алддаг. Гэхдээ ямар ч нөхцөл байдалд байлаа гэсэн сэтгэлийн хүч хат бүрмөсөн арилан алга ч болдоггүй, эсвэл хамгаас хүчирхэг ч болдоггүй.

Кармын үл буцах буюу үл харих зарчим.

Бид үйлийг л сонгож болдоггоос биш, уг үйлийнхээ үр дагаврыг бол сонгож чадахгүй гэдэг кармын хуулийн гол чухал зарчмыг дахин санацгаая. Үйлийн үр дагавар нь биднээс, та нар кармын хуульд итгэдэг үү үгүй юу, энэ хуулийг хүсэж байна уу үгүй юу гэж асуулгүйгээр ирдэг бөгөөд нарийн (буюу далд) эсвэл бүдүүн (буюу ил) түвшинд илрэн гардаг. Кармын мөн чанарыг бид ойлгох ёстой. Үйл үйлдэгдсэн л бол түүнийг буцаах аргагүй, тэр бол буцалтгүй, харилтгүй. Хуруу гохон дээр дарсан л бол сум гараад шунгинан нисээд явчихдаг. Санаж бодож байснаа өөрчлөх, дахин нэг бодож үзэх боломж хэдийнээ үгүй болсон байдаг. Иймээс оюунлаг хүмүүс үйлээ сайтар бодож эрэгцүүлж байж хийж үйлддэг. “Долоо дахин хэмжиж байж нэг удаа огтол.” гэдэг үг ч байдаг.

Бүр илүү нарийн жишээ авч үзье. Бумаренгийг нэгэнт шидчихсэн л бол түүнийг зогсоох арга байхгүй. Тэрээр байгалийн хуулийн дагуу нисээд, хэсэг хугацааны дараа бидэн дээр мөн л байгалийн хуулийн дагуу буцаж ирдэг. Ердийн бумаренг бол бидэн дээр анх шидэхэд ямар байсан тэр л хэвээрээ буцаж ирдэг. Кармын бумаренг бидэн дээр мөн л буцаж ирдэг, гэхдээ ирээдүйн амьдралуудын маань явцад огтын өөр шинж чанартайгаар буцаж ирнэ.

Кармын хуулийн шугаман бус байдал.

Аливаа үйлийн үр дагаврыг энэ ертөнц дэх зөв шудрага ёсны баталгаа— Дээд Сүнс тодорхойлдог. Ирээдүйд бидэн дээр юу “ирэх” ёстойг буюу өөрөөр хэлбэл ирээдүйд бид юу “хүртэх” ёстойг тооцоолох, дүгнэх явцдаа Дээд Сүнс энэ эсвэл тэр үйлийг үйлдэж байгаа хүний зорилго, сэдэл болон санаа бодлыг бүрэн төгс байдлаар харгалзан үзэж тооцдог.

Тэр бүү хэл орчин үеийн эрүүгийн хууль зүйд ч гэсэн гэмт хэргийг хорон муу санаагаар буюу зориуд санаатайгаар эсвэл санамсаргүйгээр үйлдсэн эсэхийг харгалзан авч үздэг. Энэ дэлхийн шүүгчдийн мэдрэхүй төгс төгөлдөр бус учраас ял оноох шийдвэр гаргах явцдаа алдаж байж болох. Тэгвэл Дээд Сүнс бүгдэд нэвчин түгдэг бөгөөд амьд оршнол бүрийн сэтгэлд, дотоодод юу болж явагдаж байгааг бүгдийг нь мэддэг болохоор бидний юу хүртэх ёстойг ямар ч алдаа мадаггүй, өө сэвгүйгээр нарийн тодорхойгоор хэмжиж оноож өгдөг. Иймээс энэ ертөнцөд шудрага бус явдал гэж байдаггүй.

Кармын хуулийн шугаман бус байдлын жишээ болгон шастираас дараахь жишээг авч үзэж болно.

Материаллаг буянт үйл үйлдэхийг, тухайлбал өглөг тараахыг зөвлөсөн байдаг смрити-шастируудаас Шрила Вишванатха Чакраварти Тхакур иш татсан байдаг: Зохистой хүнд өргөл болгон өргөж байгаа мөнгө маань бид дараагийн амьдралдаа ядуу зүдүү амьдрахгүйн баталгаа болдог. Брахмана-д өргөл өргөж байвал зохино. Брахмана бус хүнд, өөрөөр хэлбэл брахманы шинж чанарыг агуулаагүй хүнд мөнгө өгөх аваас тэрхүү мөнгө дараагийн амьдралд минь бидэн дээр тэр хэмжээгээрээ буцаж ирнэ. Хагас дутуу боловсорсон брахмана-д өргөл өргөх аваас хоёр дахин их хэмжээгээр буцаж ирнэ. Брахманы бүхий л эрхэм сайн шинж чанаруудыг агуулсан номч мэргэн хүнд мөнгө өргөх аваас зуу зуу, мянга

мянга дахин их хэмжээтэйгээр буцаж ирнэ. Харин веда-парага буюу Ведийн зам мөрийг таньж мэдсэн хүнд мөнгийг өргөл болгон өргөх аваас тэрхүү мөнгө маань тоо томшгүй олон дахин өсөж үржин буцаж ирдэг. Бхагавад Гита-гийн (15.15)-д батлан өгүүлсэнчлэн, ведаиш ча сарваир ахам эва ведйах Ведийн мэдлэгийн оргил нь Бурханы Бодьгал Шри Кришнаг ойлгож ухаарах буюу Түүнд хүрэх явдал. Хэн нэгэнд өгсөн мөнгө маань ямар нэгэн хувь хэмжээтэйгээр бидэн дээр заавал буцаж ирдэг.

Өөр нэг жишээг Шримад Бхагаватамын (5.26.3)-аас татъя: Буянтай сайн янз бүрийн үйлүүд үйлдсэнээр хүн диваажингийн гаригууд дээрх ямар нэгэн байр сууринд хүрдэг, тэгвэл буянтай бус үйлүүд нь түүнийг тамын янз бүрийн нөхцөл байдлуудад оруулдаг. Харанхуй мунхагийн гунад өдөөгдөн байгаа хүн буянтай бус үйлүүдийг хийж үйлддэг ба харанхуй мунхагт хир зэрэг автан байгаагаас нь түүний орж очих тамын нөхцөл байдал нь хамаардаг. Ухаангүй байдлынхаа улмаас харанхуй мунхагт үйл хэргээ хийж үйлдэж байгаа хүнийг арай бага хүнд хэцүү зовлон шаналал хүлээдэг. Буянтай үйл нь буянтай бус үйлээс юугаараа ялгаатай вэ гэдгийг мэддэг хэдий ч буянтай бус үйлийг үйлдэж байгаа хүн дунд зэргийн хүнд хэцүү зовлон шаналал бүхий тамд унадаг. Харин хамгийн хүнд бэрх тарчлал, зовлон шаналал бүхий тамын нөхцөл байдалд атейст үзлээсээ болоод буянтай бус хийгээд харанхуй мунхаг үйл үйлдэж байгаа тийм хүн орж унадаг.

Хүнд хэцүү карма.

Үүнтэй холбогдуулан хүнд хэцүү карма гэж юу болохыг ойлгох нь чухал. Хүзүү толгойгоо маажих зэрэг ялих шалихгүй үйлүүд нь энэ амьдралд ч тэр, мөн ирээдүй хойчийн амьдралд ч тэр төдийлөн ноцтой үр дагаврыг авчирдаггүй, үзүүлдэггүй. Гэхдээ л нүгэлт үйлүүд зовлон бэрхшээл, шаналалыг авчирдаг, араасаа дагуулдаг. Ийм үйлүүдийн дунд ирээдүй хойчийн олон олон амьдралын туршид үргэлжлэн багасан хорогдох хүнд хэцүү үр дагавруудыг авчирдаг тийм үйлүүд ч байдаг.

Кармын хүнд хэцүү үр дагавар бүхий амьд оршнолууд эдгээр гаригууд дээр унаж очих бөгөөд өнгөрсөн үедээ үйлдсэн үйлүүдэд таарч нийцсэн зовлон шаналалын янз бүрийн хэлбэрүүдийг туулж эдэлдэг. Тэд эдгээр шийтгэл гэсгээлийг үхэж үрэгддэггүй тийм өвөрмөц нарийн биеийг аван тэсвэрлэн туулдаг. Тамд авдаг тэрхүү нарийн бие нь эвдэрч сүйдэх болон задарч муудах боловч хурднаар эргэн сэргэж хуучин байдалдаа ордог ба амьд оршнол авч хүртэх ёстой бүхнээ бүгдийг нь туулж эдэлж дуусах хүртлээ түүнийг орхиж чадахгүй.

Тамын гаригууд дээр юу болж, юутай учирдагийг аугаа хаан Джанакад үзүүлдэг тухай Падма-пуранад өгүүлдэг. Энэхүү аялалынхаа явцад тамын ертөнцийн албатууд Джанакад дараахь зүйлсийг үзүүлдэг: “Энэ хүн сайн найзынхаа эхнэрийн толгойг эргүүлсэн, иймээс тэр 10 000 жилийн туршид улайдмал төмөр гулдмайд дурлан татагдах болно, дараа нь гахай болон төрнө, түүний дараагаар хүн болж төрнө, гэхдээ тэр үедээ тэр хөнгөлөгдөж тайган болно.” Ийм байдлаар, энэхүү үйлийн үр дагавар нь там, гахай, тайган гэсэн ирээдүйн гурван амьдралын туршид үргэлжилж байна. Энэ бол тэрхүү амьд оршнолын хувьд урьдаас тогтоогдсон тэр зүйл буюу түүний хувь тавилан.

Нөгөө талаас, эргэж буцах шугаман бус байдал гэж байдаг. Энэ нь Бурханы чин бишрэлийн албанд өчүүхэн бага ч гэсэн үйлчлэн зүтгэсэнээр хүн маш ноцтой гэж нэрлэж үзэж болох алдсуудыг саармагжуулж болдог гэдэгт оршдог. Ийм үйлдлийн жишээ бол энэ ертөнцөд чин бишрэлийн алба зүтгэлийн биелэл (Бхакти-дева) болдог Туласи модыг тойрон явах.

Шри Туласи Прадакшина— мантра-д ийн өгүүлдэг: “Шримати Туласи Деви-г тойрон явж байгаа хүн хийж үйлдэж байж болох бүхий л нүглээсээ, тэр бүү хэл брахманыг хөнөөх шиг тийм нүглээс ч хүртэл, алхам бүртээ салан ангижирч байдаг.

Ариун гэгээн бишрэлтэн (брахмана)-г хөнөөх нь кармын хэмжээсээр онцгой хүнд үйл байдаг бөгөөд тамыг үл оролцуулаад олон муу үр дагавруудыг ирээдүй хойчийн олон амьдралын туршид дагуулдаг, учруулдаг. Харин алуурчин элдэв муу сэдэл шалтгаан агуулалгүйгээр Туласи-г цагийн зүүний хөдөлгөөний дагуу зүгээр л тойрон явах аваас энэ бүгдээсээ ариусдаг.

Гэхдээ энд, хүн аливаа үйлийг ямар сэдэл шалтгаанаар үйлдэж байгааг бүрэн төгс төгөлдөр байдлаар авч үзэж, харгалзан тооцдог. Харин хэн нэгэн хүн: “Энэ чинь гэм нүглээ наманчлах гайхамшигтай арга байна. Хэдэн хүн цааш харуулчихаад, дараа нь Туласи-г тойрон явъя.” хэмээн бодох аваас балран сүйрэх нь тэр. Бхакти-тай харьцах харьцаандаа ноцтой алдас хийж байгаа учраас тэрээр гэмт үйлдлийнхээ бүхий л үр дагаврыг бүр илүү хүнд хэлбэртэйгээр хүртэх болно. Бүхний Дээд Бурхан Өөрт нь үйлчлэн зүтгэх чин бишрэлийн алба зүтгэлийг ёс журамгүй, увайгүй хүмүүс гэмт үйлдлийнхээ ул мөрийг баллан арилгадаг шалны алчуур болгон хувиргахыг зөвшөөрдөггүй.

Иймд хүнд карма бол муу үр дагавраа ирээдүй хойчийн олон амьдралын туршид учруулдаг нүгэлт

үйл юм. Тэдгээрийг бүрмөсөн шавхан барагдуулахад нилээдгүй олон удаагийн амьдрал шаардагдана (Тухайн хүн Бүхний Дээд Бурханы чин бишрэлийн албанд үнэнчээр үйлчлэн зүтгээгүй тохиолдолд).

Кармын хуулийн үйлчлэл нөлөөллийн механизм.

Кармын үйлээс энэ үйлийн кармын үр дагавар бий болох шилжилтийн үе шатуудыг мэдэж байх нь чухал. Кармын механизмыг Веданта-сутра, Шримад Бхагаватам болон Падма-пуранад үндэслэн тодорхойлцгооё.

Үйл үйлдэх нь үр тарьж суулгахтай төстэй юм. Тарьсан үр ургадаг, соёолж нахиалдаг, дараа нь үр жимсээ өгдөг. Үр боловсрох цагт бид өөрсдийгөө хэмээн адилтган үзэж байгаа бие махбодь маань энэхүү үрийг гашуун байна уу эсвэл амттай байна уу гэдгээс үл хамааран хэрэглэх болно. Үрийг хэрэглэхэд түүний хэмжээнээс хамаараад мөн л тодорхой цаг хугацаа ордог, шаардагддаг. Урьд өмнө ярьсанчлан, үйлийн үр дагавар нь үйлчлэл нөлөөллөө хэд хэдэн амьдралын туршид үзүүлэхээр хуваагдан байж болох. Өөрөөр хэлбэл хэд хэдэн үр болон хуваагддаг. Энэ бүх үрнүүд багц буюу хэсэг бүлэг болон хуран цогцолдог. Багц үр дагавар бүр нэг тодорхой амьдралд зориулагддаг буюу боловсордог. Энэхүү нэг амьдралын туршид энэ багц буюу бүлэг үрийг энэ бие махбодь хэрэглэж эдлэх ёстой болдог.

Бие махбодь ээлжит багц үрүүдээ дуустал хэрэглэсэн цагт энэ бие махбодийн үхэл ирдэг. Багц дууссан хийгээд өөр үр байхгүй болсон мэт санагдаж байж болох. Гэхдээ хуучин багцын хажуугаар шинэ шинэ багцууд бий болон хуримтлагддаг. Бие махбодийн үхэлтэй хамтаар тэд хүчин төгөлдөр болж эхэлдэг ба сүнс шинэ бие махбодийг авдаг. Энэхүү шинэ бие махбодь кармын үр дагаврын шинэ багцыг эдэлж хэрэглэх ёстой болдог ... гэх мэтээр цааш үргэлжилдэг. Ийнхүү амьд оршнол дахин дахин төрөх болон үхэх ёстой болдог. Үхэл төрөлтийн эцэс төгсгөлгүй үргэлжлэн эргэлдэх хүрдийг самсара гэж нэрлэдэг. Энэхүү эргэлдэх хүрднээс мултран гарахын тулд кармын хүлээс, боолчлолоос чөлөөлөгдөх хэрэгтэй. Хэрхэн чөлөөлөгддөг талаар бид ангижралын тухай ярих үедээ авч үзэх болно. Одоохондоо кармын механизмын талаар үргэлжлүүлэн ярьцгаая.

Кармын үр дагавар боловсорч гүйцэх үе шатууд.

Кармын үр дагавар бүр дараахь дөрвөн төлөв байдлын аль нэгэнд оршин байдаг:

1. Уугандаа байгаа үр.
2. Газарт цацсан үр.
3. Соёолж нахиалах, цэцэглэх болон үр гарч эхлэх.
4. Үр боловсорч дуусах болон түүнийг хэрэглэх

Эдгээр дөрвөн төлөв байдлууд дараахь нэр болон утга учрыг агуулдаг:

А) Апрабдха-пхала илэрч гараагүй байгаа үр төлөв. (Үр дагавар бол байгаа, гэхдээ дараагийн амьдралуудад илрэн гарах болно.)

В) Биджа— үр хэлбэрт байгаа үр дагавар (Үр дагавар бол байгаа бөгөөд энэ амьдралын хугацаанд илрэн гарна. Гэхдээ цаг нь болоогүй байгаа үед тэдгээр үр дагаврууд илрэн гарахгүй.)

С) Кута— илрэн гарч байгаа үр дагавар (Үр дагавар илрэн гарч эхлэнэ. Ямар нэгэн үр дагавар бидэн дээр ирж бууж байгааг тухайн тэр үр дагавар ямар байхаас хамааран сайн эсвэл сайн бус гэсэн илрэх тодорхой шинж тэмдэг болон зөн совин, ёроор харж мэдэж болно.)

Д) Прарабдха-карма (буюу пхалонмукха)— бүрэн илрэн гарч байгаа кармын үр дагавар болон түүнийг хэрэглэх үйл явц. Хүн өөрийн бүдүүн бие махбодь эсвэл нарийн бие махбодид буюу ухаан, оюун болон хуурамч эго-д таашаал ханамж эсвэл зовлон шаналалыг авчрах, учруулах үр жимсийг авдаг.

Цаг хугацаа өнгөрсөн, одоо болон ирээдүй гэсэн байдлаар урсдаг. Тухайн агшин бүрийг бид одоо байдлаар мэдэрч хүлээж авдаг, туулдаг, гэвч шууд дараагийн агшин гэхэд л одоогийн байсан агшин өнгөрсөн агшин болдог. Бид амьдралынхаа агшин бүрт л ямар нэгэн үйл үйлддэг, өөрөөр хэлбэл кармын үр дагаврын үрийг тарьж суулгаж байдаг бөгөөд тэдгээрийн нэг бүр нь соёолох, цухуйх, ургах болон боловсрох өөр өөр цаг хугацаатай. Үр жимснүүд янз бүрийн цаг хугацааны дараагаар ирдэг буюу илрэн гардаг гэдгийг онцлох нь чухал.

Жишээ нь, би одоо нэг үйлдэл хийлээ. Түүний хариу, үр дагавар нь секундын дараа ч эсвэл хэдэн амьдралын дараагаар ч ирэх буюу илрэн гарч байж болно. Ямар хугацааны дараа эдгээр үр жимсүүд боловсорч гүйцдэг, хариу үр дагавар байдлаар бидэн дээр ирдэг нь мэдэгддэггүй. Үүнийг судалдаг эрдэм ухаан байдаг ч гэсэн кармын хууль бол илүү дээд эрэмбийн хууль бөгөөд эгэл жирийн хүмүүс үзэж хэрэглэх боломжгүй, тэд түүнийг ойлгохгүй. Иймээс Бхагавад Гита-гийн 4.17-д Бурхан Шри Кришна: “Үйлийн ээдрээтэй, нарийн төвөгтэй байдлыг ойлгоход маш бэрхтэй, хэцүү. Ийм учраас үйл,

хориглосон үйл болон үйл бус гэж юу болохыг нарийн сайн мэдэх хэрэгтэй.” гэж айлддаг.

Кармын ээдрээтэй, нарийн төвөгтэй байдал нь юунд оршдог вэ?

Кармын нарийн ширийн зүйлсийн тухай бүү хэл, зарчмуудынх нь тухай ярьсан ч ойлгож хүлээж авах нь зарим хүмүүсийн хувьд маш хүнд хэцүү байдаг. Гэхдээ тэдгээр зарчмуудыг бид мэддэг байх хэрэгтэй. Кармын хуулийн зарчмын ерөнхий нөхцөл, талуудыг мэднэ гэдэг нь энэ бүх ээдрээтэй нарийн төвөгтэй байдал нь юунд байдаг хийгээд онцгой эрчим буюу чадварыг агуулаагүй хүн тэдний ээдрээг гаргаж тайлахад яагаад ингэж ярвигтай байдгийг ойлгож мэдэхийг хэлдэг.

Кармын ээдрээтэй, нарийн төвөгтэй байдлыг ойлгох нь яагаад ийм хүнд бэрх байдаг юм бол? Үүнийг шүүхийн жишээн дээр ойлгохыг чармайцгаая. Шүүх үйл явцад шүүгч нь шүүгдэгчийн бүхий л үйлүүдийг нэгтгэн дүгнэж, шинжилдэг. Бүхий л үйлдлүүдийг нь нарийн шинжилж үзсэнийхээ дараа ял оноодог. Харин гэмт хэрэгт сэжиглэгдэн шүүгдэж байгаа хүний гэм буруугүй гэдгийг тодорхойлох эсвэл түүнд ял оноохдоо шүүгчийн удирдлага болгодог хуулиудын бүхий л нарийн ширийн төвөгтэй зүйлүүдийг эгэл жирийн хүмүүс мэддэггүй. Үүн лугаа, эгэл жирийн хүмүүс нь сая тарьж суулгасан үр чухам хэзээ боловсорч гүйцэхийг ойлгох тийм төлөв байдалд байдаггүй. Жишээлбэл, тун удахгүй хариу үр дагавар нь илрэн гарах тийм үйлдлийг би сая хийсэн байж гэж үзье. Гэхдээ энэхүү хариу үр дагавартай нэгэн зэрэг, хэдэн амьдралын өмнө үйлдсэн үйлийн маань үр дагавар хамт ирдэг, илэрдэг. Энэ бол нэг үр дагавар биш, харин хоёр үр дагавар холилдон нэгэн зэрэг илэрч байна гэдгийг би яг таг мэдэж чадах билүү? Тэгж чадлаа гэхэд эдгээр нь ямар хэлбэрийн үр дагаврууд вэ гэдгийг яг таг ойлгож чадна гэж үү? Тэдгээр нь аль амьдралдаа үйлдсэн үйлийн маань хариу үр дагавар юм бол? Энэ тал дээр миний хийж чадах юм бол ердөө л таах.

Магадгүй, миний хэлж чадах цорын ганц зүйл бол дараахь зүйл л байх: Эдгээр үр дагаврууд нь надад таашаал ханамж эдлүүлж байвал тэдгээр нь миний өнгөрсөн үедээ хийсэн сайн үйлүүдийн үр дагавар, харин зовоож шаналгаж байх аваас гэмт муу үйлдлүүдийн маань үр дагавар байж таарна.

Яг ямар үйлдлүүд байсан бэ? гэдгийг нь би хаанаас мэдэх билээ дээ? Би тэдгээрийг хир эрт, хэзээ үйлдсэн байж таарах вэ? Үнэндээ бол, бурханлаг талдаа хөгжил дэвшил (материаллаг талдаа амжилт гаргахад ч тэр) гаргахын тулд энэ бүхнийг мэдэхийн хэрэг надад огтхон ч байхгүй. Энэ бол Дээд Сүнсний түвшинд ажилладаг илүү дээд эрэмбийн хууль. Заримдаа үүнийг ойлголгохгүйгээр бид буруу дүгнэлтийг хийдэг: “Ай энэ бол миний өчигдрийн хийж үйлдсэн сайн үйлийн хариу, үр дагавар байна. Өчигдөр би нийтийн тээврийн унаанд суун зорчиж байхдаа нэг хөгшинд суудлаа найрсгаар тавьж өгсөн, дараа нь зам хөндлөн гаргаж өгсөн юм. Иймээс өнөөдөр манай усны хоолойгоор халуун ус ирж, гоожиж байна. Бурхан надад ивээлээ хайрлаж байх шиг байна.”

Энэ бол алдаатай, буруу бодол. Яагаад?

Нэгдүгээрт, бид өнгөрсөн үедээ (түүний дотор өнгөрсөн амьдралууддаа) ямар үйлүүд үйлдсэнээ бүгдийг нь бүрэн дүүрэн мэдэхгүй.

Хоёрдугаарт, тэд хир зэрэг боловсорч гүйцэж байгаа болон яг хэдийд үр нөлөө үзүүлэхийг бид мэдэхгүй.

Гуравдугаарт, янз янзын үйлүүдийн хэд хэдэн үр дагаврууд бие бие дээрээ овоорон хуримтлагдаж байгаад нэгэн зэрэг илрэн гардаг гэдгийг бид харгалзаж үздэггүй.

Энэ мэдээлэл зүгээр л н нууцлагдмал байдаг. Иймэрхүү зүйлд орж хүрэх эрх хэн дуртайд нь олгогддоггүй. Энэ талын мэдээлэлд хүрэхийн тулд хүн дараахь шинжүүдийг агуулсан байх ёстой. Үүнд:

1. Бхагавад Гита-гийн (18.42)-д тодорхойлон өгүүлсэн: амар амгалан, өөрийгөө эзэмдэн захирсан, огоорсон, цэвэр ариун, тэвчээртэй, үнэнч шудрага, цэцэн мэргэн болон шүтлэг бишрэлтэй байх гэсэн брахманы шинж шинж чанаруудыг бүгдийг нь өөртөө бүрэн хэмжээгээр хөгжүүлсэн байх. Цэвэр ариуны гунад бүрэн батжин бэхжсэн зөвхөн тийм хүнд л өнгөрсөн цагийн тухай мэдлэгийг Дээд Сүнс нээдэг.

2. Тэрээр эх сурвалж парампара буюу багш шавийн барилдлагааны гинжин хэлхээнд хамрагддаг байх ёстой.

3. Джйотиша-шастра буюу Ведийн зурхайн эрдэм ухаанд гүн гүнзгий нэвтэрсэн байх ёстой.

Дараахь зүйлийг дахин онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Бурханлаг хөгжил дэвшилд хүрэхийн тулд өнгөрсөн кармынхаа энэ бүх хэрэглэсэн, бохирдож бузартсан дотуур хувцас бүхий уут савыг уудлан онгичохын шаардлага байхгүй. Цаг хугацаа, эрч хүчээ тийш хандуулж зориулж, зарцуулахын хэрэггүй. Тэгээд хааш нь, юунд зарцуулах хэрэгтэй гэж? Хамгийн гол нь, ариун гэгээн бичээсүүдэд энэ цаг үед өөрийгөө ухаарахуйн арга зам болгон зөвлөсөн тэр бурханлаг үйл, замд л эрч хүчээ оруулах хэрэгтэй.

Энэ арга зам буюу йуга-дхарма бол Кали юга дахь бүхий л хүмүүст зориулагдсан гол эм. Шримад Бхагаватын (11.5.32)-д өгүүлсэнчлэн, энэхүү аргыг үл тоон, эс ойшоох хүнийг оюунлаг гэж нэрлэх аргагүй.

Олон хүмүүс өөрсдийгөө хүүхэд мэт авч явдагийг харж болно. Ухааныхаа хүүхдийн гэмээр сониуч зан, шохоорхолоо хангахын тулд хүмүүс өөрсдийн кармын талаар хэн дуртайгаасаа түүний мэдлэг чадварыг нь үл анхааран асууж явдаг. Өөрөөр хэлбэл, тэд хууртагдаж мэхлэгдэхэд бэлэн байдаг. Иймээс л хууран мэхлэгчид гарч ирдэг. Эрэлт нь нийлүүлэлтийг бий болгодог, төрүүлдэг. Өөрийгөө “карма-г оншлогч” хэмээн зарлахдаа огтхон ч ичиж зовдоггүй хүмүүс гарч ирдэг. Тэр бүү хэл, тийм хүмүүс өөрсдийн таамаглал дээрээ үндэслэн бүхэл бүтэн номууд бичих явдал хүртэл бий. Уншигчид ч мэдлэг чадварыг нь шалгалгүйгээр тэдэнд итгэдэг.

Хүмүүсийн кармаг хардаг байхын тулд хүн Дээд Сүнснээс билгийн харааг хүртэх ёстой. Дээд Сүнстэй холбогдоно гэдэг бол амар хялбар хэрэг биш. Дээд Сүнстэй холбоотой байна гэдэг юу гэсэн үг болохыг Бхагавад Гита-“гийн (6.7-8)-д ийн өгүүлдэг: “Ухаанаа ялан дийлсэн хүн Параматмад хүрдэг. Ийм хүн амар амгалан болсон байдаг бөгөөд түүний хувьд баяр хөөр болон уйтгар гуниг, халуун болон хүйтэн, хүндэтгэл болон доромжлол ялгаагүй, цөм адил байдаг. Тэрээр хайрга, чулуу эсвэл алт ч бай ялгаагүй бүгдийг нэг л адил байдлаар хардаг.”

Тухайн хүн ямар мэдлэг чадвартайг мэдэхийн тулд хоёр параметр бүхий энгийн тестийг явуулаад үзэх хэрэгтэй:

1. Эх сурвалж мэдлэг. Түүний хамаарагдаж байгаа багш шавийн барилдлагаа холбоо ямар зорилготой?

2. Сэдэл. Өөрөөр хэлбэл тэрээр ашиг завшаан хайж байгаа эсэх. Алт болон чулуу хоёрын хооронд хир зэрэг ялгаа гаргаж байна вэ гэдгийг харж мэдэх. Брахмана мэдлэгээрээ бизнес хийдэггүй. Тэрээр зөвхөн бусдын өргөсөн өргөлөөр л амьдралаа залгуулдаг. Ашиг завшаан үл хайж, хайр харамгүй байна гэдэг бол зүрхний цэвэр ариуныг заадаг. Зүрх нь цэвэр ариун бус байх аваас Дээд Сүнснээс билгийн хараа хүртэх тухай ямар ч яриа байх аргагүй.

Урьдаас тогтоогдсон байдал болон сэтгэл зоригийн чөлөөт байдал хоёрын хослол.

Үйлүүд кармын хуулийн дагуу болзолдож нөхцөлддөг, эсвэл бидний ирээдүйн бие махбодтой болж тохиолдох цаашдын учрал, үйл явдлууд урьдаас тодорхойлогдсон байдаг. (Бид өөрсдийгөө бие махбодтойгоо адилтган үздэг учраас “Энэ явдал надад болж тохиолдож байна.” хэмээн ярих дуртай.) Ийнхүү урьдаас тогтоогдчихсон буюу шийдвэрлэгдчихсэн явдал нь сэтгэл зоригийн буюу сонголт хийх эрх чөлөөт байдлын зарчимтай нийцдэггүй гэж зарим хүмүүс ярьдаг. Шримад Бхагаватамын (11.3.6)-ын тайлбарт ийн өгүүлдэг: Жишээ нь би нислэгийн тийз худалдаж аван, бүртгэл шалгалтын хэсгийг өнгөрөн шатан хоолойгоор дамжин онгоцонд орж суулаа гэж бодъё. Онгоц хөөрмөгц л нисэх гэж гаргасан шийдвэр маань уг онгоцыг газарт буух хүртэл намайг түүний бүхээгт байхаас өөр аргагүй байдалд тулган оруулдаг. Өөрөөр хэлбэл нислэгийн явцад бууна гэсэн яриа байж болохгүй гэсэн үг. Ийм байдлаар би өнгөрсөн үедээ гаргасан шийдвэр болон үйлдсэн үйлийнхээ үр дагаврыг хүлээж авахаар тулгагддаг. Би онгоцонд суун өнгөрсөн үедээ гаргасан шийдвэр, үйлийнхээ үрийг туулж эдэлж байгаа хэдий ч шинэ шинэ шийдвэрүүдийг гаргах болон үйлүүдийг хийж үйлдэж байж болно. Үйлчлэгч бүсгүй надад хоол, унд авчирахад би түүнийг нь хүлээн авч эсвэл татгалзаж байж болох. Мөн сонин, сэтгүүл унших, унтах эсвэл бусад зорчигчидтой ярилцах болон өөр бусад үйл хийж байж болно. Өөрөөр хэлбэл, ерөнхий утгаараа тодорхой нэг хот руу хийж буй энэхүү нислэг онгоцоор нисэх гэсэн өнгөрсөн үедээ гаргасан шийдвэрийн маань хариу үр дагавар байдлаар надад хүчээр тулгагдан ирж байгаа буюу намайг хүчээр уяж ороож байгаа хэдий ч энэхүү нөхцөл байдалд орсон байгаа би байнгад шийдвэр гаргаж, шинэ үр дагавруудыг бий болгодог. Жишээ нь, би архи дарс уугаад хэрүүл маргаан хийж үймээн самуун дэгдээх эсвэл хэн нэгнийг үйлээрээ доромжилж басамжилж байж болох, үүнээс болоод намайг онгоц газардсаны дараагаар баривчлан авч явах болно. Эсвэл эсрэгээр, хажуу дэргэдээ сууж яваа бизнесментэй танилцан сайн харьцаа тогтоох аваас энэ нь ирээдүйд бизнесийн ашигтай гэрээ хийхэд ч хүргэж байж болох (Хэрвээ би мөн бизнесмен бол.). Үүнтэй төстэйгөөр, амьд оршнол нь кармын хуулийн дагуу тодорхой нэгэн бие махбодийг авахаас өөр аргагүй байдалд тулгагдан ордог хийгээд энэ бие махбодидоо амьдрангаа тодорхой байдалд орж байж болох ч сэтгэл зоригийн буюу сонголт хийх эрх чөлөө болон өөрийн гэсэн шийдвэр гаргах боломж түүнд үргэлж байдаг.

Ихрийн амьдралын түүх.

Сонголт хийх эрх чөлөөний үлгэр, тодотгол болгон Америкийн нэгэн ихрийн жишээг татъя. Тэдний

төрсөн цаг хугацаа болон газар орон нэг ижил. Иймээс тэдний заяа төөргийн зурлага мөн л адилхан, нэг ээжтэй, Америкийн ядуувтар гэр бүлд төрсөн. Гэхдээ хачирхалтай нь хувь заяагаараа тэд маш өөр болох нь харагдсан. Олон жилийн туршид тэд адил төсөөтэй нөхцөл байдал, үйлүүдийг туулсан. Гэсэн ч тэдний нэг нь архичин, гэмт үйлтэн болсон бол нөгөө нь амжилт бүтээлээр дүүрэн, аз жаргалтай сайн иргэн. Яагаад ийм болчихов хэмээн эхнийхээс нь асуухад тэрээр, хүүхэд ахуй үеийн минь нөхцөл байдал би юу ч хийж чадахааргүйгээр тийм муу байсан болоод л ийм болчихлоо гэж хариулсан.

Харин нөгөөгөөс нь асуухад тэрээр, хүүхэд ахуй үеийн маань нөхцөл байдал бүгдийг засаж сайжруулахыг чармайхаас өөр аргагүй тийм муу байсан гэж хариулсан. Энэ бол тэд сонголтоо янз бүрээр буюу өөр өөрөөр хийсний үр дүн.

Кармын тухай сэдвээ цааш илүү дэлгэрэнгүйгээр үргэлжлүүлэе.

Махабхарата-д өгүүлсэнчлэн, хүний амьдрал бол өмнөх, буруу амьдралынх нь хариу буюу өр төлөөс бөгөөд тугал бэлчээрт байгаа зуу зуун үнээдийн дотроос эхийгээ үргэлж олдогтой адилаар карма эдлүүлэх ёстой хүнээ мөн л яг олдог. Иймээс үйлээ цэцэн мэргэн байдлаар үйлдэх хүсэл хүнд илрэн гарсан буюу төрсөн байх ёстой. Ийм хүсэл үгүйн уршгаар хүн зохистой бус үйлүүдийг хийж үйлддэг бөгөөд сансрын шудрага ёсны хуулийн дагуу тэдгээрийнхээ үр дагаврыг туулж эдлэхээс өөр аргагүй байдалд тулгагдан ордог.

Карма— сансрын хууль.

Сансар буюу космос нь грек үг бөгөөд “цэгц журамтай, оюунлаг систем буюу тогтолцоо” гэсэн утгыг илэрхийлдэг. Сансар бол бүх зүйлс нь утга учир болон өөрийн гэсэн логиктой цэгц журамтай систем. Түүнд өөрийн гэсэн хуулиуд байдаг. Хуулиуд бол итгэлээс гадуур оршдог. Би итгэж байна уу үгүй юу гэдэг нь чухал биш: хууль бол хууль, сансрын хүрээ хязгаарын дотор хүчин төгөлдөх байж үйлчлэл нөлөөллөө үзүүлдэг.

Шинэ од бий болох буюу төрөх болон хажуугийн өрөөнд хүүхэд уйлах гэх мэтээр орчлонд болж явагдаж байгаа бүхэн кармын хуультай холбоотой, хамааралтай.

Карма болон хувь заяа.

Барууны бүх философчдыг нэг талаас урьдаас тогтоогдсон байдал буюу хувь заяаны тухай номлолын төлөөлөгчид, нөгөө талаас сэтгэл зоригийн эрх чөлөөт байдлын тухай номлолыг баримтлагчид гэсэн хоёр хэсэгт хувааж болно. Хоёр тал хоёулаа маргалдаан булаацалдааны бүрхэг битүү төлөв байдалд оршицгоодог.

Хувь заяагаа дийлж давах хүч бидэнд байдаггүй гэдэг нь сэтгэл зоригийн эрх чөлөө байдаггүй гэсэн үг биш. Карма өөрөө бол үйлийн зөвхөн дөрөв дэх үе шатыг буюу хэдийнээ болж явагдчихсан тэр зүйлийг (прабандха) төлөөлдөг.

Өмнөх гурван үе шат гэж байдаг бөгөөд бид тэдгээрийн талаар товч авч үзсэн билээ.

Эхний үе шат бол биджа. Үгчилбэл “үр” гэсэн утгатай. Энэ бол үрийн хэлбэрт байгаа карма. Нөхцөл байдал нь тааламжтай болох аваас үрнээс кармын үр жимс урган гардаг. Үнэндээ энэ бол бидний хүслүүд. Материаллаг ч бай, эсвэл бурханлаг ч бай тэдгээр хүслүүд биднийг энэхүү тодорхой хүслээ биелүүлэх үү эсвэл үгүй юу гэдэг шийдвэрийг гаргахад хүргэдэг. Энэ бол хоёр дахь түвшин буюу үе шат.

Кута-стха— шийдвэр гаргах үе шат. Энэ үе шатанд бид аюултай шийдвэрийг гаргалгүйгээр үлдэх чадвартай. Хэрвээ үйл тэртэй тэргүй л үйлдэгдчихсэн байх аваас энэ нь хэдийнээ дараагийн үе шатандаа орчихсон байна гэсэн үг. Энд дараахь зүйлсийг ойлгох шаардлагатай. Хүслүүд бол нүгэлтэй болон нүгэлгүй гэж байдаг. Тэдний заримыг нь тэвчиж байж болдог бол бусдыг нь тэгж тэвчих аргагүй. Зарим хүслийг тэр бүү хэл тэвчих нь хүртэл аюултай. Жишээ нь, бие махбодиос гадагшлах ялгадсыг цаг тухайд нь гаргаж байхгүй бол хүнд өвчин тусаж байж болно.

Нүгэлт хүслүүдэд хоёр янзаар хандаж болно. Эхнийх нь, тэдгээрийг зүгээр л тэвчиж болно, тэгэх аваас тэдгээр хүслүүд тэвчил хатамжлалын галд шатна. Гэхдээ тэвчихэд тийм ч амар хялбар бус хүслүүд бас байдаг. Тийм хүслүүдийг Бурханы албанд үйлчлэн зүтгэхэд хандуулан хамруулж оролцуулан ариусгах шаардлагатай. Тухайлбал, бэлгийн таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл маш хүчтэй байж болох ч хүн сайн сайхан гэр бүлтэй болж сексийг хүүхэдтэй болохын тулд зориулах аваас энэхүү хүсэл ариусдаг. Энэ талын мэдлэг нь хүслийн нүгэлтэй болон нүгэлгүй хэлбэрүүдийн тухай хийгээд нүгэлтэй хүслүүдийг ариусгах болон тэвчих чадварын талаар бүрэн ойлголт төсөөллийг өгснөөр карма-гаас чөлөөлдөг. Ийм мэдлэгтэй болохын тулд бурханлаг номын багшид шавь орох нь зайлшгүй чухал.

Пхалон-мукха— энэ бол үйлдэл үйлдэгдсэний дараа эхэлдэг үе шат. Үр дагаврын гинжин хэлхээ эхэлж,

мөн кармын хүрд хуйлран эргэлдчихсэн хэрэг. Үүний үр дүнд, энэ үр дагавруудын сүүлчийн гинж нь дахиад л би байх болно. Өмнөх үе шатуудад байсан эрх чөлөө төгсгөл болсон байна. Энэ хуулийн үр дүнд бидний үйлдэл зүй тогтоолоороо дуусгавар болдог. Энэ бол прарабдха үе шат.

Үүнээс үзэхэд, хувь заяа гэж бидний нэрлэдэг зүйл бол кармын хуулийн дагуу бидэн дээр ирж байгаа үр дагаврууд юм. Эдгээр үр дагавруудын учир шалтгаан нь үргэлж бид өөрсдөө байдаг. Библьд: “Хүн юу тарина, түүнийгээ хурааж авна.” гэж өгүүлдэг. Карма хэлбэржин бий болохын жинхэнэ учир шалтгаан бол бидний материаллаг ухамсартайгаар үйлдэж байгаа үйл ажиллагаа. Таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл үйл үйлдэхэд хүргэдэг, энэ үйлдэл түүнийг дахин дахин үйлдэх хүслийг төрүүлдэг.

Иймээс бид аз жаргалтай эсвэл зовж шаналж байгаагийнхаа хариуцлагыг өөр хэн нэгнээс эрж хайх нь тэнэг хэрэг болно. “Би хэн нэгэн рүү хуруугаараа чичлэхэд хариуд нь над руу гурван хуруугаараа чичлэх болно.” гэсэн Энэтхэгийн цэцэн мэргэн үг байдаг.

Сайн сайхан болон муу муухай.

Сайн сайхан болон муу муухайн талаарх ойлголт нь харьцангуй юм. Жишээ нь: хэн нэгэнд хоол болж байгаа юм бусдад нь хор болдог. Үүгээр л бидний сэтгэл зоригийн эрх чөлөөт байдал тодорхойлогдож байгаа учраас ийм л байх ёстой. Гэхдээ бүхий л дэлхий ертөнцийн тухай яриа өрнөж явагдаж байх аваас сайн сайхан болон муу муухайн тухайд сансрын норм хэмжээ, журмууд байдгийг хүлээж авах шаардлагатай. Эдгээр норм хэмжээ болон журмуудын талаар Ведийн бүтээлүүд болон өөр бусад бичээсүүдэд тодорхойлон өгүүлсэн байдаг. Жишээ нь, ойр дотныхноо хайрлах, хүнд хэцүү байдалд байгаа хүнд туслах, шалиг завхай явдал үл гаргах гэх мэт үйлүүдийг сайн хэмээдэг. Нөгөө талаас, хүч хэрэглэх болон алж хөнөөх зэрэг үйлүүдийг муу үйлүүд гэж үздэг.

Ёс суртахууны сансрын норм хэмжээ, дүрэм журмыг ойлгож байгаа хүн ямар ч нөхцөл байдалд байсан гэсэн харьцангуй дүрэм журмууд дээр биш, харин глобал үнэн дээр үндэслэж суурилан үйлээ зөвөөр хийж үйлддэг. Үнэмлэхүй ёс суртахууны талаар эрэгцүүлэн бодож тунгааж байх аваас кармын үр дагавруудтай учрах буюу кармын үр дагавраа эдэлж туулах үедээ бид зохих ёсны дүгнэлтүүд хийх бөгөөд ингэснээр өөрсдийнхөө жишээ туршлага дээр суралцдаг.

Амьдралд маань болж тохиолдож байгаа үйл явдал бүр бидний хувьд сансрын ёс суртахууны хичээл сургамж болж байх ёстой. Аль ч амьдрал ёс суртахууны болон ариун гэгээн байхуйн сургууль болох ёстой бөгөөд ингэж байх аваас бид нэгэн амьдралынхаа явцад төгс төгөлдөрт хүрч чадна. Ёс суртахууны төгс төгөлдөр норм хэмжээ болон дүрэм журмуудыг агуулсан ном бүтээлүүдийн хамгийн шилдэг нь бол Ведийн бүтээл Бхагавад Гита бөгөөд түүнийг үзэж судалснаар бид үүсэн бий болсон буюу учирч тулгарсан ямар ч нөхцөл байдалд зөв үйлдэл хийхэд суралцана.

Карма бол хүслээ биелүүлэх үйл явц.

Бидний аливаа хүсэл кармын хуулийн дагуу биелсэн байдаг. Бидний хүсэл болон бидний боломж гэсэн хоёр хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой. Хүсэл маань заримдаа бидний боломжтой таарч нийцдэггүй буюу хүслээ биелүүлэх боломж бидэнд үргэлж байгаад байдаггүй. Боломжийг өөрт одоо байгаа мөнгөтэй зүйрлүүлж болох бөгөөд тэрхүү мөнгө маань хүсэж зорьсон төлөвлөгөөгөө хэрэгжүүлж биелүүлэхэд хүрэлцэхгүй байх үе ч байдаг. Гэхдээ кармын хуулийг ашигласнаар өөрт байгаа арга хэрэгслийн нөөцөө нэмэгдүүлэх, ингэснээр бодож санаж байгаагаа биелүүлж болдог.

Зөвхөн нэг л хүслийг биелүүлэх боломжгүй. Энэ бол Бурхан болох, Бурхан байх гэсэн хүсэл. Энэхүү байр суурь угийн Эзэнтэй.

Бид хэн ч байж, юу ч хийж байж болох бөгөөд үнэ цэнийг нь ариун гэгээн бичээсүүдэд угийн заачихсан байдаг. Гэхдээ бид тэрхүү үнийг төлөхөд бэлэн байгаа билүү?

Гэвч хамгийн гайхалтай, жигтэй нь иймэрхүү бодол санаа биднийг эрхэм дээд зүйлд хүргэдэггүй. Үүнээс гадна шинэ шинэ материаллаг бодол санаагаа хэрэгжүүлэн таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл бол нүгэлт үйл бөгөөд ийм үйл үйлдэхийг урьд өмнө зажилж байснаа дахин зажилж байгаатай зүйрлүүлж адилтгаж үздэг. Ухамсраа хөгжүүлэх зам мөрөөр замнаж байгаа хүн материаллаг төлөвлөгөөнөөсөө татгалзах болон материаллаг хүслээс бүрнээ салж ангижрах хэрэгтэй байдаг.

Кармын ангилал

Санчита-карма. Энэ бол хүний төрлийг аван төрсөн урьд өмнөх амьдралуудаас хуримтлагдан ирсэн бүх кармын бүрэн тэнцэл, тооцооны дүн юм.

Прарабха-карма. Энэ бол одоогийн энэ амьдралд зориулагдсан “таатай сайн” болон “таагүй муу” үр дагаврууд юм. Прарабха-карма өөрчлөгддөггүй бөгөөд түүнийг зөвхөн тэвчин өнгөрүүлэх болон зохих ёсны дүгнэлтүүдийг хийж болно.

Крийаман-карма. Энэ бол прарабха-кармын онцлог байдлаар хязгаарлагдсан чөлөөт сонголтын хэсэг. Энэ хэсэгт үйлдэгдсэн үйлүүд ирээдүйн төрөлтүүдэд илрэн гарах (сайн эсвэл муу) үр дагавруудыг бий болгодог эсвэл үхэл төрөлтийн хүрээнээс мултран салж ангижрахад хүргэдэг. Ямар шинж чанартай үйлийг сонгох вэ? гэдэг сонголт нь бидний ухамсрын шинж чанараас хамаардаг бөгөөд энэхүү шинж чанар нь сайн болон сайн бус байж болдог.

Сайн ухамсар.

Сайн ухамсар нь өөртөө бус, харин бусдад ач тусыг үзүүлэх хүслийг төрүүлдэг. Энэ бол хөгжиж байгаа ухамсрын шинж тэмдэг бөгөөд ийм ухамсар бүхий бодьгалтай харьцаж байвал бидэнд ачтай, тустай. Ер нь бол сайн бодьгал адил түвшний харьцааг өөрөө эрж хайж явдаг, иймээс түүнтэй холбоо харилцаа тогтоох нь хүнд бэрх биш. Ухамсрын энэ түвшин дэх харьцаа нь таатай бус нөхцөл байдал үүсэж байгаа үед ч гэсэн ханамжийг авчирдаг. Үүний шалгуур болгоод амьдралд маань таагүй байдлыг бий болгоод байгаа тийм нөхцөл байдлыг авч үзье. Жишээ нь, хөрш айлынхан чинь ханандаа тавиур тогтоох гээд түжигнүүлээд байна. Харин та унтмаар байдаг. Хөршдөө туслахыг чин сэтгэлээсээ хүсэж байх аваас та орноосоо босоод түүн дээр очин туслаж болно. Энэ бол сайн ухамсрын жишээ. Харин ухамсарт чинь уур хилэн бадарч, таагүй байдлыг гаргаж, төрүүлээд байгаа тэрхүү үүр уурхайг нам дарах хүсэл төрж байж болно. Тэгвэл энэ бол сайн бус ухамсрын шинж тэмдэг.

Сайн бус ухамсар.

Сайн бус ухамсар бусдын ашиг сонирхлыг үл харгалзан өөртөө л, өөрийнхөө санаанд тааруулж үйлээ хийж үйлдэхийг албаддаг. Хар амиа бодсон ийм үйл ажиллагаа нь нийцэл зохицлын хуулийг зөрчиж, түүнтэй харшилдаг бөгөөд ийм шинж чанар бүхий бодьгалтай холбоо харьцаатай байх нь бидний ухамсрын хөгжил дэвшилд мөн л таатай бус байх болно.

Аагами-карма. Энэ бол одоогийн энэ амьдрал маань бидний сүүлчийнх биш байх аваас ирээдүйн амьдралд илрэн гарах карма.

Викарма. Энэ бол Бурханы хуулиудыг үл тоон эс хайхрахад, төрөлт үхлийн хүрдэнд хэвээр үлдэн уналт доройтолд ороход болон амьтадын амьдралын хэлбэрт тоо томшгүй олон удаа төрж эцэс төгсгөлгүйгээр зовж шаналахад хүргэдэг буруу үйлүүд юм. Викарма бол акармын шууд яг эсрэг байдал нь. Викарма үйлийн дөрвөн хэлбэрт илэрч тодорч байж болно:

-Эцэг эхийн эсрэг чиглэсэн үйлүүд.

-Гэр бүлийн эсрэг чиглэсэн үйлүүд.

-Нийгмийн эсрэг чиглэсэн үйлүүд.

-Хүн төрөлхтний эсрэг чиглэсэн үйлүүд.

Хамт олны карма. Хүн төрөлхтөний ирээдүйд үйлчлэл нөлөөллөө үзүүлэх карма бол хамт олны карма. Энэ бол тодорхой хамт олонд буюу хэсэг бүлэгт багтаж байгаа бүх хүмүүсийн нэг бүрийн кармын нийлбэр юм. Жишээлбэл, онгоцны эсвэл автобусны ослоор нас барагсад тохиолдлоор нэг дор цуглараад амиа алдаж байгаа хэрэг биш.

Хамт олны кармын хууль нь биднийг нэг адил үйлийг хийж үйлдэхийг тулгадаг бөгөөд үүндээ харгалзан нэг адил үр дагаврыг авчирдаг. Үүнээс үзэхэд хүн өөрийгөө яаж авч явж байна түүнийг тийм л ирээдүй хүлээдэг. Хүмүүс нядалгааны шинэ шинэ газруудыг нээж байгаа цагт дайнууд гарсаар үргэлжилсээр байх болно.

Карма болон эрүүл мэнд.

Викарма нь бурхангүйн үзэлд хүргэдэг, Бурханд итгэх итгэлээ хаяж гээхийг Чарака Самхитагийн дагуу бол бүхий л өвчний үндэс гэж үздэг. Аюрведийн байр сууринаас үзвэл, хамгийн адгийн буюу нэн муу карма бол яльгүй, дэмий зүйлээс болж сэтгэл зовох зуршил. Падма Пуранад өгүүлсэнчлэн, сэтгэл зовох зуршлаас буюу сэтгэл байнгад тавгүй байхаас дор гаслан зовлон гэж байдаггүй. Иймээс ийм зуршил бие махбодийг сулруулдаг, доройтуулдаг. Бид үл ялих зүйлд, тэр нь хайрцаг чүдэнз ч байж болно эсвэл машин ч байж болно, ихэд уягдан сэтгэл татагддаг бөгөөд тэгээд түүнийгээ хулгайд алдчих вий, эвдэрчих вий, эсвэл хуучраад муудчих вий гэх мэтээр, янз бүрийн байдлаар сэтгэл түгшин зовнидог. Энэ нь орчин үеийн судалгаа шинжилгээгээр батлагдаж байгаа бөгөөд сэтгэлийн хямрал буюу стресс бол 20 дугаар зууны номер нэг хөнөөгч гэж үздэг нь учиртай хэрэг.

Бүдүүн болон нарийн түвшний карма.

Бүдүүн түвшний ч тэр, мөн нарийн түвшний ч тэр үйлүүд нь үр дагаврыг дагуулдаг. Урьдын цагт бол бүдүүн түвшний кармын үр дагаврууд нь тэр бүү хэл дотоод хүсэл болон бодол санаа— зэрэг нарийн

түвшний кармын үйлүүдээс хүртэл болж ирдэг байсан.

Харин одоо кармын хууль нь бүр илүү төвийг сахьсан байдалтай болсон бөгөөд нарийн хэлбэрийн кармын үйл нь араасаа сэтгэл зовнил, сэтгэлийн таагүй байдал, сэтгэлд сэв суух... гэх мэтээр илэрдэг нарийн түвшний кармын үр дагавруудыг дагуулдаг болсон.

Ийм үр дагавруудаас ариусах нь нарийн түвшинд ч тэр, мөн бүдүүн түвшинд ч тэр боломжтой. Нарийн түвшний талдаа бол бид наманчилж, дотооддоо харьцаагаа өөрчилж, дахиад ингэж болохгүй гэж өөртөө амлаж болно. Бүдүүн түвшний талдаа бол бодлынхоо гүнд байгаа объектын өмнө уучлал эрэх,?????, ухаанд бодогдож байгаа таатай бус байдлуудад бие махбодиороо орохоос зайлсхийх зэрэг хэлбэрээр шууд хийж үйлдэж болно.

Кармаас ангижрах.

Хүн хүртэх ёстой зовлон зүдгүүрийг туулж эдлэх эсвэл хийж үйлдсэн гэм нүглээ гэмшин бүрэн наманчлах аваас үр дагаврууд хүчингүй болно, Кармын үр дагавар нь сэтгэлийн түгшүүр зовиур, тайван бус таагүй байдлын хэлбэрээр илэрдэг. Иймээс, бид гэм нүглээ үнэн сэтгэлээсээ гэмшин наманчлах хийгээд уучлалт эрж байгаа цагт тайван амгалан байдал ирдэг. Иймэрхүү өдөр тутмын наманчлалыг унтахынхаа өмнө хийж байвал муу биш бөгөөд ингэх нь хийсэн алдааныхаа байр сууринаас буюу дахин тийм алдаа гаргахгүйн үүднээс ирж буй маргааш өдрийнхөө тухай бодох болон тайван сайхан амрах боломжийг өгдөг. Бурханлаг номын нэгэн багш ийнхүү гайхамшигтайгаар хэлсэн байдаг: “Өдөр бүр бид, өчигдөр хийж үйлдсэн сайн бүхнээ болон бусдын зүгээс бидэнд учруулсан, хийсэн муу муухай бүгдийг гэсэн хоёр зүйлийг мартаж байх ёстой. Мөн бид өдөр бүр бодож санаж байх хоёр зүйл бол: Бурхан; мөн үхэл хэзээ л бол хэзээ ирж байж болно гэдэг тухай юм.”

Бүрнээ гэмшиж наманчлахыг, орчин үед хийдэгчлэн, долоо хоногт нэг удаа сүмд очихоос ялгаж салгах нь чухал. Хүн гэмшиж наманчилсныхаа дараагаар тэр үйлээ дахин цааш үргэлжлүүлэн хийсээр байх аваас түүний карма улам л нэмэгдэх болно. Учир нь, энэ бол басамжилж доромжилж байгаа буюу алдас хийж байгаа ухамсрын амьд жишээ. Нүгэлт үйл ажиллагаанаас бүрнээ салж холдсоноор кармагаас бүрэн салж ангижирдаг. Бурханд итгэх итгэлтэй болсноор ийм түвшинд хүрдэг. Итгэлгүй байна гэдэг бол бүхий л кармын үйл ажиллагааны анхдагч учир шалтгаан. Гэхдээ кармаг Удирдан залагч— Бурханд хандсанаар нүгэлт үйлүүдийнхээ бүхий л үр дагавруудаас хурдан түргэн хийгээд эргэлт буцалтгүйгээр салж ангижирдаг.

Нүгэлт үр дагаврын тоо хэмжээг килограммаар, тонноор эсвэл сая сая амьдралаар ч хэмжих аргагүй. Хүн өөрийн хүч чадлаар хуримтлагдсан үр дагавраасаа өчүүхэн төдий хэмжээгээр ч салан ангижрах боломжгүй. Харин чин сэтгэлээсээ гэмшин байгаа гэмшил наманчлалын хариуд болгоон хүртээж байгаа Бурханы өршөөл нигүүлсэл ирж тулгарч байгаа үр дагавруудын тоо болон чанарыг өөрчилж, мөн зогсоох чадвартай.

Карма болон цаг хугацааны хамаарал.

Үнэ цэнэтэй цаг хугацаагаар алдаж үрэгдүүлэх нь хамгийн хүнд хэцүү зовлон шаналалт байдалд хүргэдэг. “Он жилүүдийг ямар ч зорилгогүйгээр өнгөрүүлсэн байна хэмээн хожим нь харамсахгүйгээр тэгж амьдрах хэрэгтэй.” гэж Островский бичсэн байдаг.

Хийж амжаагүй аливаа үйл нь удаан үргэлжлэх таагүй байдлыг төрүүлдэг. Их дээд сургуульд элсэн орж чадсангүй гээд жилийн туршид шаналах тийм хүн байдаг. Хүүхэд төрүүлж чадаагүй эмэгтэй хүн бүхий л амьдралынхаа туршид шаналдаг. Иймээс өөрийн үүргээ тодорхой сайн ойлгож цаг хугацаанд нь биелүүлэх хийгээд маш анхааралтай байх нь чухал.

Карма болон амьтад

Амьтны бие махбодийг аван төрөх төрөлт нь кармаг бий болгодоггүй. Амьтны бие махбодь бхога-йона хэлбэртэй, амьтад зөвхөн л таашаал ханамж эдэлдэг эсвэл зовж шаналдаг.

Карма болон оноогдсон үүргүүд.

Кармын үйлүүд бол зовлон шаналалд хүргэдэг үйлүүд юм. Чухамдаа бол, аливаа материаллаг үйл болон бодол санаа нь нэг бол сайн эсвэл сайн бус үр дагаварт хүргэдэг. Гэхдээ аль ч тохиолдол нь байсан гэсэн зовлон шаналал илрэн гардаг. Диваажинд ч эсвэл тамд ч байсан гэсэн бид ямар нэгэн шалтгаанаар зовлон шаналалыг амсаж эдлэх л болно. Диваажин— энэ бол сүнсний оршин байх мөн л түр зуурын орон бөгөөд мэдрэхүйн таашаал ханамжийг илүү удаан хугацаагаар хийгээд илүү ихээр амталж эдлэх боломж бүхий дээд түвшний гаригуудын бөөмнөрөл юм. Гэхдээ л цаг нь болоод тэндээс холдох болоход мөн л маш ихээр эмзэглэж хөндүүрлэх болно. Үүнийг амралтанд амрахтай зүйрлүүлж

болно. Амралтын газарт хөгжилтэй байж, зугаалж цэнгэх нь сайхан, гэвч мөнгө дуусаж буцах хэрэгтэй болдог.

Зовлон шаналалыг төрүүлдэггүй, зовлон шаналалд хүргэдэггүй үйл яаж үйлдэх вэ?

Ийм үйл нь хүч хэрэглэх болон хүч үл хэрэглэх түвшингээс дээш оршдог. Хүч үл хэрэглэж байгаа хүн хүнд хэцүү кармын үйл үйлдэх тохиолдол маш олонтаа байдаг. Жишээ нь, гэмт хэрэгт анхаарал үл хандуулж байгаа цагдаагийн албан хаагч. Энэ бол оноогдсон үүргийн түвшин. Кармын хууль бол энэ түвшнээс илүү дээш. Энэ амьдралдаа хүмүүст ач тус хүргэхэд ямар байдлаар суралцах ёстойг оноогдсон үүргүүд тодорхойлдог. Цагдаа хүн хүч хэрэглэн хамгаалах ёстой бөгөөд энэ бол түүний үүрэг. Надад ямар үүрэг оноогдсон бэ? гэдгээ тодорхой ойлгосон байх аваас үүргээ биелүүлэх нь үргэлж ариусгадаг.

Оноогдсон үүргүүд гэдэг бол өнгөрсөн амьдралаас минь бидний араас сунаж ирсэн буюу дагаж ирсэн уялга, өр юм. Энэ бол өнгөрсөн амьдралдаа өөртөө болон хүмүүст хандуулж чадаагүй бидний чадварууд.

Эмэгтэй хүний үүрэг бол ариун гэгээн хүүхдүүдийг хүмүүжүүлэх, харин эрэгтэй хүний үүрэг бол энэхүү хүмүүжлийн төлөөх хариуцлагыг өөртөө авах явдал. Худалдаачны үүрэг бол мөнгө олох болон түүнээсээ ариун гэгээнтэнгүүдэд, сүмд өргөл болгон өргөх. Багшийн үүрэг бол шавь нартаа дээдийн дээд мэдлэгийг хүртээж тэднийг төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлөөс ангижруулах.

Өөрт оноогдсон үүргээ ийнхүү биелүүлж байгаа хүн аз жаргалтай болдог. Ухаан бодолд нь эргүүлж төлөөгүй байгаа өрний асуудал нь дарамт болж байх аваас хүн амар тайван байх ч боломжгүй. Энэ талын бүрэн ойлголттой болохын тулд кармын сүүлийн төлөв болох акарма-г авч үзэх нь зайлшгүй чухал.

Акарма.

Акарма нь бүхий л төрлийн кармаас, төрөлт үхлийн хүрднээс ангижрахад хүргэдэг. “А” гэсэн угтвар нь үгүйсгэлийг заадаг, акарма нь “кармагүй” эсвэл “үйл бус үйл” гэсэн угтгатай. Үйл бус үйл гэж юу вэ? Энэ бол араасаа үр дагавар дагуулдаггүй үйл. Эндээс үзэхэд ийм үйл нь энэхүү материаллаг ертөнцтэй холбоогүй болно. Ийм үйлийг трансцендент үйл гэдэг. Мөн түүнийг өөрөөр бурханлаг буюу Бурханд үйлчлэн зүтгэхтэй холбоотой үйл гэж нэрлэдэг.

Хэдийгээр бид таатай болон таатай бус үр дагавруудын тухай ярьдагч гэсэн үнэмлэхүй утгаараа бол таатай үр дагавар гэж байдаггүй. Үр дагавар гэж байгаа л бол энэ нь таатай бус төлөв байдал. Баяр хөөрийн дараагаар зовлон шаналал, уйтгар гуниг үргэлж болдог, ирдэг. Үүнийг савлуур, дүүжинтэй зүйрлүүлж болно. Дүүжинг нэг тийш нь хэдийчинээн ихээр түлхэнэ, нөгөө тийшээ төдийчинээн их хол савладаг. Иймээс кармын нөлөөн дороос бүрнээ гарах хэрэгтэй.

Өөрийгөө ухаарч танин мэдэхүйн түвшинд хүрсэн хүн бүхий л хэл яриа, бодол санаа болон үйл хэргээ Бурханд зориулдаг хийгээд Бурханы түүнээс хүсэж байгааг л буюу Бурханы таалалд нийцэж байгааг л хийдэг учраас кармын хуулинд захирагдах албагүй болдог. Үйл хэргээ байнгад ийм ухамсартайгаар явуулснаар акарма-гийн энэ түвшинд дээшлэн хүрч болно.

Бхагавад Гита-д Кришна Арджунад хандан ийн айлддаг: “Өөрийгөө ухаарахуйн бүхий л зам мөр буюу шашны бүхий л хэлбэрүүдийг орхин Надад зүгээр л өөрийгөө даатга. Би чамайг бүхий л нүгэлт үйлийн үр дагавруудаас салган ангижруулна.”

Тэгэхлээр, Бурханд үйлчлэн зүтгэх алба (бхакти-йога)-ын тусламжтайгаар Түүний таалалд өөрийгөө даатгах нь кармаас салан ангижрах хийгээд акармын түвшинд дээшлэн хүрэх арга зам юм. Бхакти болон карма нь оюуны үйл ажиллагааны хоёр горим. Карма ухамсрыг ийш тийш самгардуулдаг бол бхакти түүнийг нэгэн чиглэлтэй болгодог. Бурханыг хайрлах цэвэр ариун хайр гэж юу болохыг ойлгосон хүн ариун гэгээнтэн болох буюу амьдралынхаа төгс төгөлдөрт хүрэхээр жинхэнэ шийдвэр төгс болдог учраас өмнөхөөсөө 100 дахин илүү их хүч гарган ажиллаж эхэлдэг. Хүний амьдралын зорилго бол кармын бүхий л төрлөөс чөлөөлөгдөн ангижрахад оршдог. Энэ зорилгодоо хүрээгүй байх аваас хүний амьдралын хэлбэрийг аван төрсөн төрөлт нь хий дэмий өнгөрчээ гэж үздэг.

Йогын зам мөрийг (Акармын эх булагтай холбоо тогтоох арга) даган замнах хэрэгтэй. Ингэж байж л кармын бүх төрлөөс ангижрах хийгээд үхэл төрөлтийн хүрднээс мултран гарах болно. Энэ талын хамгийн үр дүнтэй шилдэг сайн арга бол Харе Кришна Харе Кришна Кришна Кришна Харе Харе/Харе Рама Харе Рама Рама Рама Харе Харе— маха-мантра-г давтан уншдаг мантра-бясалгал юм. Энэ

нь бидний одоо амьдран байгаа, бүх нийтийн уналт доройтлын цаг үе Кали юга-д зориулагдсан арга болно.

Акарма-гийн төгс төгөлдөр түвшинд хүрсэн хүн: омог бардам зангүй, материаллаг дурлан татагдлаас огоорсон, эргэл мөргөлийн ариун дагшин газар оронд очих дуртай, тайван амгалан, нэг ч секундыг хий дэмий хоосон өнгөрөөдөггүй алддаггүй, Бурханы зүгт буцан харих халуун хүсэлтэй, хэдийгээр өөрөө олон янзын дутагдал сул талуудтай ч Бурхантай гүн гүнзгий харилцаа холбоотой болно гэсэн итгэл найдвар дүүрэгтэй, Бурханы ариун гэгээн нэр алдрыг магтан дуулах байнгын хийгээд гүн гүнзгий дур амттай, Бурханы шинж чанаруудыг бахдан алдаршуулах дуртай гэсэн шинж чанаруудтай болдог.

Хачин жигтэй дахин төрөлт хийгээд уналт доройтолд хүргэдэг үйлүүдийн шинж тэмдгүүд.

Бид амьдралаа мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйл ажиллагааны маш нарийн төлөвлөгөө боловсруулахад зориулан үрэн таран хийж шал дэмий хоосон өнгөрөөж, ариун гэгээн байдалд хүрэх эсвэл дутагдал, сул талуудаасаа бүрнээ ангижран салах— хамгийн гол төлөвлөгөөгөө хийхийг мартчихдаг. Энэ бол амьдралын маань хамгийн гол үйл явдал— үхэлд хачин жигтэй хайхрамжгүйгээр хандаж байгаагийн илрэл юм.

Махараджа Юдхиштхира 5000 жилийн өмнө: “Элэнц хуланц, өвөө, эцэг нь нас барсан ч хэн бүр өөрөө бол үхэхгүй юм шиг бодож явдаг нь бүхнээс хачин жигтэй, хачирхалтай.” гэж хэлсэн байдаг.

Лев Толстой: “За яахав, чи Самарт 60 га газар, 200 морьтой байг гэж бодъё. Тэгээд дараа нь? Чи Гоголоос, Пушкинаас, Шекспирээс, Мольерагаас, ер нь дэлхийн бүх зохиолчдоос ч алдартай болж байж болно. Тэглээ гээд яана гэж? Одоо биш ч гэсэн, маргааш өвчин тусаж болно. Үхэл бол бүх хүмүүс дээр, хэн дээр ч ирнэ. Өмхий самхай болон өт хорхойноос өөр юу ч үлдэхгүй. Намайг бүгд мартана. Хүн үүнийг харахгүй байж яаж чадаж байна вэ? Энэ чинь л ёстой хачирхалтай хэрэг биш гэж үү.”

Дахин төрөхүйн үзэл нь маш олон төрөлтэй бөгөөд соёлын болон шашны бүтцүүдэд байдаг. Тухайлбал, Ведийн номлол, хойд Америкийн индианчуудын янз бүрийн омгуудын космологийн системүүд, Платоны философи болон неоплатонизм, орфийн соёл болон эртний Грекийн бусад мистик шашнууд, мөн эрт үеийн Христын шашинд.

Орчин үеийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээнүүд нь дахин төрөхүйн онолтой холбоотой зарим сонирхолтой зүйл үзэгдлүүдэд анхаарлаа хандуулж байна.

Бидний бие махбодь долоон жил тутамд өөрчлөгддөг гэдгийг шинжлэх ухааны замаар баталсан. “Та бол таны идэж байгаа тэр зүйл, өөрөөр хэлбэл бие махбодийн эсүүд өөрчлөгддөг, үс ургадаг, сахал ургадаг. Ингээд долоон жилийн хугацаанд бидний бие махбодийн бүхий л элементүүд өөрчлөгддөг, солигддог. Жишээ нь, та одоо 21 настай байг гэж бодъё. Тэгвэл та хэдийнээ 3 удаа дахин төрсөн байна гэсэн үг. Та бие махбодио 3 удаа сольсон байна. “Би дахин төрнө гэдэгтээ итгэхгүй байна.” гэж та хэлж байж болох. Энэ бол итгэлийн асуудал биш. Энэ бол баримт. Хоол идэх бүртээ л та дахин төрж байдаг— шинэ мах цусыг, шинэ бие махбодийг үүсгэх буюу төрүүлдэг. Ийнхүү бидний бие махбодь өөрчлөгддөг гэдэг нь илэрхий болж байна. Бид огт өөр бие махбодьтой болдог. Тэр бүү хэл урьд өмнө нь байсан бие махбодийн эсүүдээс ч үлдэхгүй. Шүд өөр болсон, үс сахал өөрчлөгдсөн. Бид дахин төрсөн. Иймээс дахин төрөлт байдаг эсэх тухай асуух ч хэрэггүй юм. Дахин төрөлт бол илэрхий зүйл, бид дахин төрөхийг туулдаг буюу дахин төрдөг. Хэн бүр л хүүхэд байсан, харин одоо том болж насанд хүрсэн буюу дахин төрсөн. Иймээс “Би бол бие махбодь.” гэх нь зохистой биш. Бхагавад Гита-гийн (2.13)-т ийн өгүүлдэг: “Сүнс нь энэхүү бие махбодио нялх балчираас эхлэн идэр залуу дараа нь өтөл буурал болтол хувирч өөрчлөгдөхийг даган байсаар үхлийн дараагаар өөр бие махбодид шилжин ордог. Өөрийн бурханлаг мөн чанараа ойлгож ухаарсан хүн ийм шилжилт өөрчлөлтөнд төөрөлдөж самуурдаггүй, тавгүйтдэггүй.”

Бид бол бие махбодь биш. Иймд, би бие махбодь биш байх аваас, би бол америк хүн биш, би бол мексик хүн биш, би бол орос хүн биш, мөн би бол цагаан арьстан биш, би бол хар арьстан биш, мөн би бол эрэгтэй хүн биш, би бол эмэгтэй хүн биш. Би бол ийм ч жинтэй биш, тийм ч жинтэй биш, би бол ийм ч өндөр биш, тийм ч өндөр биш. Би бол энэ бүгд биш. Би бол эдгээр бие махбодиудаар аялж яваа цэвэр сүнс. Энэ бол баримт. Гэвч харамсалтай нь, орчин үеийн нөхцөл байдалд тэр бүү хэл материаллаг

шинжлэх ухааны нэр цуутай лут мундаг профессор, докторууд хүртэл үүнд итгэдэггүй.

Өнгөрснөө санахуй.

Америкийн судлаач Станислав Гроф пранайама-гийн аргын үндсэн дээр өнгөрсөн төрлөө, хялбархан шалгаж болох бүхий л нарийн ширийн зүйлүүдийнхээ хамтаар санах боломж өгдөг ребефинг боловсруулсан.

Туршилтанд орогсод эхийн хэвлийд ямархуу байснаа буюу үе үе ирж тохиолдож байсан тэсвэрлэхийн аргагүй өвдөлт, зовлонгоо амархан эргэн санаж байсан. (Жирэмсэн эмэгтэйг тамхи татсаны 5 минутын дараагаар хэвлийд нь байгаа хүүхдийн зүрхний цохилт эрс хурдсах хийгээд амьсгалах хөдөлгөөн нь татганасан байдалтай болдог нь эмбриологийн судалгаагаар батлагдсан. Энэ бол хүүхэд тэсвэрлэхийн аргагүй өвдөлтийг амсаж байна гэдгийн илэрхий шинж тэмдэг.) Түүнээс гадна туршилтанд орогчид тэр бүү хэл амьтны төрөл (загас, шувуу, мөлхөгчид, тэр бүү хэл ургамал) аван төрсөн төрлөө хүртэл маш тодорхой санаж тэр тухайгаа ярьж байв. Биологчид тэдний ийнхүү өгүүлэхийг мөн л адилхан хүлээн зөвшөөрсөн.

Гипнозын буюу ховсын арга.

Ховсдуулагч аажим аажмаар өөрийн залуу үе, хүүхэд нас, төрсөн цаг мөч болон бүр цаашлаад өнгөрсөн үе рүүгээ буцан очдог. Үүнийг мөн баримтаар хялбархан шалгаж, баталж болдог. Туршилтанд орогч буцаж очсон тухайн тэр үеийнхээ буюу төрөлтийнхөө төрөлх хэлээр төвөггүйгээр ярьдаг. Тэр бүү хэл хоолойны өнгө нь хүртэл өөрчлөгддөг.

Өнгөрсөн амьдралаар нь эмчлэх.

Өвчин чухам юунаас болсон бэ? гэдэг учир шалтгааныг зарим үед өнгөрсөн амьдралуудаас нь эрж хайн эмчилдэг. М.Незертон эмчийн эмчилгээний аргыг АНУ болон өөр бусад орнуудад өргөнөөр мэддэг. Хурдан эдгэрдэг бөгөөд үр дүнтэй гэдэг нь мэдээж батлагдсан.

Хүлээж байгаагүй буюу гэнэтийн эргэн саналт.

Гадаад эрс огцом ширүүн үйлдэл нөлөөлөл нь өнгөрснөө эргэн санахад олонтаа хүргэдэг. Нэгэн герман охин урьд өмнө нь огт сонсож байгаагүй итали хэлээр ярьж эхэлсэн тохиолдол байдаг. Вирджингийн их сургуулийн профессор Ян Стивенсон бүр төрсөн цагаасаа л өнгөрсөн амьдралаа эргэн санаж байсан хийгээд өөрийн тэрхүү санамжаа бүрэн баталсан Имад гэдэг хүүгийн тохиолдол дээр судалгаа хийсэн. Ян Стивенсоны судалгааны ажлаас бас нэг жишээ болгон Бенгалын нэгэн төмөр замчингийн охин Суклагийн тохиолдлыг авч үзэж болно. Тэр охин дэрээ гар дээрээ аван бүүвэйлэн тоглох дуртай байсны зэрэгцээ тэрхүү дэр-хүүхдээ Мину гэж нэрлэдэг байв. Охин Мину-д яг л өөрийн охин лугаа ханддаг байсан. Суклагийн яриагаар бол тэрээр Бхатпар-д амьдарч байсан бөгөөд иймээс тийшээ аваачихыг эцэг эхээсээ үргэлж гуйдаг байлаа. Бхатпар-д Мана нэртэй нэгэн эмэгтэй үнэхээрийн амьдарч байсан хийгээд хэдэн жилийн өмнө бяцхан охин Минугаа орхиод нас барсан гэдгийг Суклагийн эцэг магадлан олж мэджээ. Ингэснээр Суклагийн эцэг охин нь урьд амьдралдаа Мана байсан гэдэгт итгэсэн. Тэд гэр бүлээрээ бүгдээрээ Бхатпар-д явж хүрэхэд Сукла Манагийн амьдарч байсан байшинд ямар ч алдаагүйгээр дагуулан очсон. Тэгээд үл таних 30 орчим хүмүүсийн дундаас Манагийн нөхрийг, түүний хадам аав, ээж, дүү нар болон мөн Минуг таньсан. Энэ болон өөр бусад олон зүйлүүд нягт нямбай шалгагдсан хийгээд батлагдсан.

Стивенсон ховсын техникт төдийлөн итгэлтэй бусаар ханддаг байсан хэдий ч “ксеноглоссийн тохиолдол” түүнийг тэрхүү хандлагаасаа тээнэгэлзэхэд хүргэсэн. Филадельфигийн нэгэн бүсгүй ховсын нөлөөн дор өмнөх амьдралаа эргэн санасан ба тэрээр шведийн фермер байсан тухайгаа ярьж эхэлсэн. Тэр бүсгүй амьдралдаа Шведэд огт очиж үзээгүй хийгээд швед хэлээр ганц ч үг мэддэггүй байсан хэдий ч ховсонд ороод швед хэлээр чөлөөтэй ярьж илэрхийлж байв. Тэнд тусгайлан уригдан ирсэн байсан швед хүмүүс тэр бүсгүйг швед хэлээр ямар ч аялгагүйгээр ярьж байна гэж баталсан. Америкчууд швед хэлний зарим нэг илэрхий үгсийг зөв хэлж дуудаж огт чаддаггүй ч тэр бүсгүй бол тийм алдаа ерөөсөө гаргаагүй, цэвэр ярьж байсан.

Мөн Бангалорын сэтгэл зүйн эрүүл мэнд болон невропатологийн институтын мэргэжилтэнүүд хүүхэд ахуй үедээ өнгөрсөн амьдралаа эргэн санаж байсан 250 бүртгэгдсэн тохиолдлуудыг судалж үзсэн. Өнгөрсөн амьдралуудынх нь талаарх санамж хүүхдүүдэд 3-7 настайд нь олонтаа ажиглагддаг гэдэг нь судалгаагаар харагдсан. Хүүхдүүдийн 82% нь өөрсдийн нэр болон өнгөрсөн амьдралынхаа талаар дэлгэрэнгүй санаж байсан, 25% нь өнгөрсөн төрөлд нь үхэлд хүргэсэн зүйлүүдээс тайлбарлахын аргагүй байдалтайгаар айж байсан. Жишээ нь, Матхурагийн нэг охин өнгөрсөн амьдралдаа худагт унан живж үхсэн учраас худгаас их айж байсан.

Зүрх шилжүүлэн суулгалт.

Сүнс зүрхний орчимд байрладаг, гэхдээ зүрх шилжүүлэн суулгалтын явцад саяхныг болтол сүнс зүрхтэй хамтаар өөр бие махбодид шилжин ордоггүй байсан. Тийм тохиолдол гарч байгаагүй аж. Сүнс шууд зүрхэн дотор байрладаггүй, харин зүрхний орчимд хийн нарийн урсгалууд дотор хөвж байдаг. Гэхдээ нэг удаа гайхалтай зүйл болсон. Зүгээр нэг дан ганц зүрх биш, харин зүрхний хамт уушиг шилжүүлэн суулгах мэс ажилбар хийгдсэн бөгөөд эмэгтэй хүний бие махбодид эрэгтэй хүн орсон байсан. Цааш нь юу болсон талаар нууцалсан.

Дур сонирхол шилжин ордог.

Дур сонирхол сүнстэй хамтаар шинэ бие махбодид шилжин ордог. Дур сонирхол нь хүн аливааг хүлээж авах уу (санкалпа), эс хүлээж авах уу (викалпа) гэдгийг хариуцдаг ухааны нарийн биед хадгалагдан, тээгдэж явдаг. Хэн нэгний үйл ажиллагааг мөн эргэлзээ, хүсэл, санамж дагалдан явдаг. Энэ бүгд нь далд ухамсарт далдлагдсан байдаг хэдий ч дур сонирхол бол бүрнээ бодитой хэвээр үлддэг.

Сайн хүүхэд бол урьд өмнө нь сайн хүүхэд байсан, харин муу нь урьд өмнө нь муу байсан (Брихад-Араньяка Упанишад 4.4.5).

Үүнтэй уялдаад буюу дур сонирхлоосоо болоод бид хөгжим, бүжиг, хоол унд болон хувцас хунараа сонгоцгоодог бөгөөд энэ бүгдийг карма гэж нэрлэж болно.

Кармын хууль бол бүх нийтийг хамардаг буюу үйлчлэл нөлөөллөө бүгдэд үзүүлдэг учир шалтгаан болон үр дагаврын хууль буюу ёс суртахууны эрчим хадгалагдах хууль: “Та юуг тарина, түүнийгээ л хурааж авна.” Үүнээс үзэхэд, бидний зовж шаналж байгаагийн учир шалтгаан бол бид өөрсдөө.

Бүү хөнөө. Кармын хууль нь хөнөөгчийг хөнөөх ялаар шийтгэдэг (Амийг амиар.). Хүн зөвхөн хүнийг биш, мөн амьтадыг хөнөөснийхөө төлөө хариуцлагыг хүлээдэг, үүрдэг.

Махыг санскритаар мамса гэдэг. МАМ— намайг, САХ— тэр. Одоо бол чи намайг хөнөөж байна, харин хожим би чамайг.

Амьтадыг нядалгааны буюу ярганы газар хөнөөхөд үүний хариуцлага зургаан хүнд оноогддог. Өөрөөр хэлбэл, мал амьтадыг нядалж хөнөөсний хариуцлагыг зургаан хүн үүрдэг. Жишээ нь үнээг хөнөөсөн буюу нядалсан тохиолдолд нядлахыг зөвшөөрсөн, нядалж байгаа, тусалж байгаа, махыг нь худалдаж авсан, махаар нь хоол хийсэн болон уг хоолыг идсэн— тэд бүгдээрээ үнээний арьсан дээр хичнээн тооны үс байна төдий чинээн олон удаа хөнөөгдөх болдог.

Шинжлэх ухааны хүлээн зөвшөөрсөн дахин төрөлтийн баримтууд.

Урьд нь бол сэтгэл судлаачид болон хий судлаачид иймэрхүү баримтуудад ухааны самуурал, өвчлөл гэсэн байдлаар ханддаг байсан. Харин тун саяхан, Европын их сургуулиудын 9 зэрэг цол бүхий доктор Александр Каннон дахин төрөлтийн талаарх 1382 баримт нотолгоог болон энэ бол бодитойгоор оршин байгаа зүйл хийгээд үүнийг судлах ёстой гэсэн бодол санаагаа нийтлүүлсэн.

Амьтны хүрээлэнд дотор нь арслан бүхий торны өмнө очсон жаалхүү ааваасаа ийн асуужээ:

-Аав аа, энэ юу вэ?

-Энэ бол арслан, араатны хаан.

-Тэр яагаад хаан гэж?

-Тэр хамгийн хүчтэй нь болоод л тэр. Тэр бол хэнийг ч гэсэн тасар татан хаяж чадна.

-Таныг ч гэсэн мөн тэгж чадна гэж үү?

-Тиймээ, торноосоо гарах аваас намайг ч гэсэн тэгж чадна.

-Аав аа тэр торноосоо гарах аваас би ямар унаагаар гэртээ харьж болох вэ?

Бид үхлийг ингэж л өөртэйгөө биш, харин өөр хэн нэгэнд хамаатуулан хардаг, үздэг. Үүний учир шалтгаан нь бид өөрийнхөө мөнхийн мөн чанарыг зөн совингоороо мэдэрдэгт оршдог, гэвч энэ мэдрэмжээ бид материаллаг бие махбодидоо хамаатуулдаг. Үүнийг хий хуурмаг байдал гэж нэрлэдэг. Дахин төрөлт— энэ бол бие махбодийн хэлбэрийн сэлгээ бөгөөд хүний амьдралын зорилго биелэгдсэнгүйн хийгээд амьтны дур сонирхлоосоо эмчлэгдэн салах шаардлагатай гэдгийн шинж тэмдэг. Шинэ бие махбодийн хэлбэр нь тухайн хүний дурлан татагдлаас хамаардаг. Бхагавад Гита-д өгүүлсэнчлэн, бие махбодио орхиж байхдаа хүн оршихуйн ямар төлөв байдлын талаар бодож байнам дараагийн амьдралдаа тэр төлөв байдалдаа хүрдэг. Хүн бүхий л амьдралынхаа туршид юу бодож байсан түүнийхээ тухай л санаж дурсдаг. Эсрэг хүйстэндээ татагдах дурлан татагдал нь дараагийн амьдралдаа хүйсээ солиход хүргэдэг, эмэгтэй хүн эрэгтэй хүний бие махбодийг авах нь эрэгтэй хүн эмэгтэй хүний бие махбодийг авахаас илүү дээр (Ш.Б.4.28.19).

Бэлгийн амьдралд дурлан татагдах буюу хуял тачаалт хүсэлд автан байхыг дурмада— буруу замаар

замнах гэж нэрлэдэг бөгөөд энэ нь нохой, гахай эсвэл сармагчингийн бие махбодийг аван төрөхөд хүргэдэг. Амьдралынхаа нөхцөл байдалд татагдаж байгаа хүнд үхлийнхээ дараагаар шинэ бие махбодид орохыг зөвшөөрдөггүй бөгөөд тэрээр хий үзэгдэл хэлбэртэйгээр зовж шаналах болдог (Ш.Б. 4.29.77). Дахин төрөлтийн хуулийн тодорхойлолт болон ийнхүү дахин төрсөн үед илэрч байгаа гэм нүглүүдийн шинж тэмдгүүдийг Бхагавад Гита, Гаруда Пурана, Сародхара болон тэдгээртэй адил төстэй өөр бусад анхдагч эх булгуудаас олж үзэж болно.

-Буянтай сүнснүүд нь өөрт оноогдсон үүргүүдээ биелүүлснийхээ үр дүнд энэ орчлонгийн диваажингийн (дээд) гаригууд дээр дээшлэн очдог.

-Өөрт оноогдсон үүргээ биелүүлэн тулалдаж яваад амь эрсэдсэн дайчин эр наран дээр очдог. Иймээс дайралт хийх үедээ тэд Ура буюу нарны гариг— Ра тийш урагшаа хэмээн хашгирдаг.

-Буянтай хийгээд үнэнч эхнэр буянтай нөхөр нь нас барсныхаа дараа хүрч очсон тэр гаригт очдог.

-Трансцендентальч нь трансцендентальчийн эсвэл элбэг хангалуун баян чинээлэг гэр бүлд төрдөг.

-Бурхан—Шүтээнд өргөл болгон өргөгдсөн ургамлын сүнс кармаасаа ариусан илүү дээд түвшний бие махбодийг авдаг бөгөөд хүний амьдралын хэлбэрт хурдан буцаж төрдөг.

-Ариун гэгээн мэргэд ариун гэгээн нууруудад яст мэлхий болон төрж байж болно.

-Харин өөрийнхөө хүчин чармайлтаар бурханлаг ертөнцөд хүрч очихыг оролдож байгаа йогч алмаз (бриллиант)-ан бие махбодийг аван төрж байж болно.

-Нүгэлт үйл үйлдэгсэд нь амьтадын амьдралын хэлбэр эсвэл газар дэлхий дээр таатай бус нөхцөл байдалд төрөл аван төрдөг.

-Биеэ үнэлэгч нь цэцэглэдэг мод болон төрдөг.

-Эсрэг хүйстэндээ дурлан татагдах явдал нь эсрэг хүйстний нь бие махбодид албадан төрүүлдэг. Анхны харцаар дурлах явдал нь үүгээр тайлбарлагддаг. Бие биедээ татагдан байгаа эрэгтэй, эмэгтэй хоёр нь адил төстэй буюу ойролцоо нөхцөл байдалд төрдөг бөгөөд эрт орой хэзээ нэгэн цагт уулзалдан бие биенээ шууд таныцгаадаг. Гэхдээ энэ тохиолдолд тэд хүйсээ сольсон байдаг.

-Бид өрөө буцааж өгөөгүй байсан байх аваас тэрхүү өрийг авах ёстой байсан тэр бидний гэр бүлд төрөх бөгөөд энэ талаар огтхон ч үл сэжиглэх буюу үл мэдэх бид өгөхгүй нууж байсан бүхнээ өгөх ёстойгоос бүр илүү ихээр маш их баяр хөөртэйгөөр буцааж өгдөг.

-Брахманыг хөнөөгч уушигны сүрье тусдаг.

-Үнээ алсан хүн бөгтөр нуруутай эсвэл ухаан муутай хүн болдог бөгөөд тэрхүү алсан үнээний арьсан дээр хичнээн үс байна, тамд төдийчинээн олон дахин төрдөг. Статистикын судалгаагаар, дундаж хүн амьдралдаа 4-өөс цөөнгүй үхэр иддэг...

-Онгон охиныг хөнөөсөн хүн уяман өвчтэй буюу нойтон хамуу тусдаг.

-Эмэгтэй хүнийг, хэвлийд байгаа үр хөврөлийг хөнөөгч олон янзын өвчин эмгэг бүхий харгис хэрцгий хийгээд хорон муу хүн болдог. Абортыг дэлхийн 3 дугаар дайн гэж нэрлэж байгаа бөгөөд хүн төрөлхтөн үүнд нүдэн балайгаар хандаж, харж байна.

-Шалиг, завхай зайдан явдал гаргагч тайган болдог.

-Багшийнхаа эхнэрийг эргүүлэгч арьсны өвчнөөр шаналах болдог.

-Амьтны махаар хооллогч амьтны төрлийг аван төрөх бөгөөд урьд нь өөрөө идсэн тэр түүнийг өөрийг нь идэх болно. Харин хүний амьдралын хэлбэртээ тэрээр улаан нүүр царайтай байх болдог.

-Архичид болон мансуурагчид шүд нь муудан зовж шаналдаг.

-Идэх ёсгүй зүйлийг ховдог шунагаасаа болон идэж байгаа брахмана бүдүүн гэдэстэй болдог.

-Амтатныг бусадтай хуваалцалгүйгээр идэгч бахлуур өвчтэй төрдөг.

-Шраддха зан үйлийн ёслолын үеэр цэвэр ариун бус хоолыг өргөл болгон өргөж байгаа хүн дараа төрөлдөө уяман өвчтэй эсвэл батгатай болдог.

-Оршуулгын газарт архи авчирдаг хийгээд уудаг бидний “соёлтой зан” нь бидэнд ч тэр, мөн талийгаачид ч тэр маш хор хөнөөлтэй. Ингэснээрээ бид түүний зовлонг зөвхөн л ихэсгэдэг. Архи дарс нь уналт доройтолд л хүргэхээс, хөгжил дэвшилд бол биш.

-Омог бардам зангаасаа болж багшдаа алдас хийж байгаа хүн унадаг өвчтэй болдог.

-Ведүүдийг болон ариун гэгээн бичээсүүдийг үзэн ядах, басамжлах хүн тун удалгүй шар өвчин тусдаг.

-Хуримын ёслолд саад хийх, үймүүлэх хүн уруулгүй болдог.

-Ном хулгайлагч хараагүй, сохор болон төрдөг.

-Үнээг зодож цохих эсвэл брахманыг өшиглөж байгаа хүн бэртэнгитэй болон хазгар доголон болж

төрдөг.

- Худалч хүн ээрүү төрдөг, ийм худалчийг сонсож байгаа хүн сонсголгүй дүлий төрдөг.
- Хор өгөгч, хордуулагч сэтгэлийн өвчинтэй болж төрдөг.
- Галдан шатаагч халзан болдог.
- Мах худалдагч амжилтгүй урагшгүй нэгэн болж төрдөг.
- Бусдын махыг идэгч өвчтэй төрдөг.
- Үнэт зүйлсийн хулгайч зарцын болон хүнд хүчир ажил хийгчийн гэр бүлд төрдөг.
- Алт хулгайлагч дараа төрөлдөө хумсны өвчтэй болдог.
- Өөр бусад металлуудыг хулгайлагч гуйлгачин болдог.
- Хоол хүнс хулгайлагч харх болдог.
- Ус хулгайлагч Чатака шувуу болдог. Энэ шувуу борооны усаар ундаалдаг.
- Үр тариа хулгайлагч царцаа болдог.
- Хор хулгайлагч хилэнцэт хорхой болдог. Орчин үеийн эм нь мөн хорны төрөлд хамаарагддаг.
- Хүнсний ногоо болон ургамал хулгайлагч тогос болдог.
- Хүж болон үнэртэн хулгайлагч заарт харх (ондатра) болдог.
- Бал хулгайлагч хөх түрүү болдог.
- Мах хулгайлагч тас шувуу болдог.
- Давс хулгайлагч шоргоолж болдог.
- Бетель, жимс болон цэцэг хулгайлагч ойн сармагчин болдог.
- Гутал, өвс болон хөвөн хулгайлагч хонины хэвлийгээс төрдөг.
- Хүч хэрэглэдэг, зам дээр дээрэм тонуул хийдэг болон ан авд дуртай хүн махаар хооллогчийн гэрт ямаа болох нь эргэлзээгүй хэрэг.
- Хор уун үхэж байгаа хүн ууланд хар могой болон төрдөг.
- Зан төрхийн хувьд тогтворгүй хүн эзэнгүй ойд заан болон төрдөг.
- Бурханд өргөл өргөдөггүй хийгээд бүх хоолоо ариусгалгүйгээр иддэг хоёрдахиа төрөгч буюу брахмана нь туулж нэвтэршгүй шигүү ойд бар болон төрдөг. Иймээс хоолоо идэхийн өмнө Харе Кришна мантра-г ядаж ганц удаа ч гэсэн уншин ариусгаж бай.
- Гаятри мантра-г уншдаггүй, дотроо хар санаатай ч гаднаа бол гэгээн буянтай царайлагч брахмана тогоруу болдог.
- Тахилга өргөл үйлдэх зохисгүй хүний төлөөнөө өргөл мөргөл үйлдэж байгаа брахмана хээрийн цагаан мөөг болдог. Ийм тахилга өргөлийг олон удаа үйлдэх аваас илжиг болон төрдөг.
- Хоолоо идэхийн өмнө мантра үл унших хүн хэрээ болдог. Хоол идэхийн өмнө уншдаг уншлага, залбирал эсвэл мантра бүхий л шашинд байдаг. Үүнийгээ бүү үл хайхар.
- Мэдлэгийг зохистой байдлаар, зохих ёсоор дамжуулахгүй байгаа хоёрдахиа төрөгч (багш) бух болдог.
- Багшдаа зохих ёсоор үйлчлэн зүтгэхгүй байгаа шавь амьтан болдог, илжиг эсвэл үнээ.
- Багшаа айлган сүрдүүлэх болон жигшин эзвүүцэх, үзэн ядах эсвэл брахманыг заналхийлж байгаа хүн демон-брахмана, брахмана-ракшаса, ямар ч усгүй эзгүй зэлүүд цөлд хорон муу сүнснүүдийн ангид төрдөг.
- Хоёрдахиа төрөгч (брахмана)-д амласнаа үл өгөгч цөөвөр чоно болдог.
- Сайн хүмүүст зочломтгой бус зан гаргагч сүүтэгнэн явах муу ёрын сүнс- хий үзэгдэл болдог.
- Найз нөхрөө хууран мэхлэгч уулын дэлт бүргэд болдог.
- Худалдаа наймаа хийхдээ залилж мэхэлж байгаа хүн ууль болдог.
- Варна-ашрама систем (Хүний нийгмийг багш, дайчид, худалдаачид болон ажилчид гэсэн анги давхаргад хуваадаг жам ёсны тогтолцоо)-ны талаар муугаар яригч ойн тагтаа болдог.
- Хайр, итгэлийг эвдэгч, эхнэрээ хайрлахаа болин хаягч удаан хугацааны туршид улаан хүрэн нугас болдог.
- Эцэг, эх, багшаа үзэн ядагч, ах эгч нартайгаа хэрэлдэгч нь мянган удаа төрөл авах явцдаа эхийнхээ хэвлий дотор хөнөөгддөг.
- Хадам аав болон хадам ээжтэйгээ муу харьцдаг хийгээд байнгад хэрүүл хийдэг эмэгтэй цус сорогч хануур хорхой болдог.
- Эр нөхөртэйгөө хэрэлддэг эхнэр бөөс болдог.
- Эр нөхрөө орхин өөр эрийн хойноос гүйж байгаа эмэгтэй сарьсан багваахай, гүрвэл эсвэл могой

болдог.

-Өөрийн гэр бүлийн хэн нэгэн эмэгтэйтэй явалдан ураг төрлийн холбоогоо хөсөр хаяж байгаа хүн баавгайн хэвлийгээс төрдөг.

-Даруу, тэвчээртэй эмэгтэйн толгойг эргүүлэн уруу татаж байгаа хуял тачаалт хүн цөл газарт хий үзэгдэл буюу буг болдог.

-Насанд хүрээгүй охидтой завхай зайдан явдлыг ургуулагч ойд үлэмж том могой болон төрдөг.

-Багшийнхаа эхнэрийг улиглан хүсэгч хамелеон болдог.

-Эзэн хааныхаа хатныг улиглан хүсэгч ёс суртахуунгүй нэгэн болж төрдөг.

-Найзынхаа эхнэрийг хүсэгч илжиг болдог.

-Байгалийн эсрэг хорон муу үйл үйлдэгч тосгонд гахай болон төрдөг. Энэ утгаараа ногоон хөдөлгөөн бол маш тустай.

-Хэтэрхий их хуял тачаалт хүн хуял ихтэй азрага болдог.

-Экадашийн өдөр мацаг үл баригч нохой болдог.

-Эд баялагтай болохын төлөөнөө Шүтээндээ мөргөдөг тийм хөөрхийлөлтэй нэгэн хоёрдахиа төрөгчийг девалака гэж нэрлэдэг бөгөөд иймээс тахианаас төрдөг.

-Брахманыг хөнөөгч илжиг, тэмээ эсвэл одос үхрээс төрдөг.

-Архичид болон мансуурагчид нь чоно, нохой эсвэл цөөвөр чононоос төрдөг.

-Багшийнхаа эхнэрийн хойноос эргүүлдэгч өвс, бут эсвэл ургамал болдог.

-Бусдын эхнэрийг хулгайлагч, хадгалсан мөнгийг нь өөрийн болгогч, брахманыг тонон дээрэмдэгч нь демон-брахмана болдог.

-Өөрийн үүргээ үл биелүүлдэг хийгээд үүний төлөөх ял шийтгэлийг хэд хэдэн тамд эдэлж туулагч хараагүй сохор хийгээд ядуу зүдүү нэгэн болж төрдөг.

-Өөрөө эсвэл өөр хэн нэгний өгсөн газрыг эргүүлэн хураан авагч 60 мянган жилийн туршид ялгадсан доторх хорхой болон төрдөг.

-Өөрийнхөө бэлэглэсэн зүйлийг хүчээр буцаан авагч нүгэлтэн орчлонгийн устал сүйрэл болтол тамд байх болдог.

-Өөрт нь амьдралаа залгуулах хэрэгсэл болгон өгсөн зүйлс болон алгын чинээ газраа тэдгээрийг дуусаж барагдах хүртэл нь хамгаалах ёстой. Тэдгээрийгээ хамгаалдаггүй, харин хулгай дээрэм хийгч нь доголлон нохой болдог.

-Брахманыг тэтгэж тусалдаг хүн ингэснийхээ үр шимийг 100 мянган үнээний үнэтэй тэнцэхүйц тийм байдлаар хүртдэг. Харин брахманыг амьдралаа залгуулах юмгүй болгон хоослогч нь сармагчин эсвэл нохой болдог.

-Бэлэг үл өгдөг хүн гуйлгачин болдог; ихээхэн ядуу зүдүү байдлаасаа болж зовж зүдрэх тэрээр нүгэл үйлддэг. Гэм нүгэлт үйл үйлдсэнийхээ уршгаар тэрээр тамд унадаг бөгөөд нүгэлтэн болохоор дахин ядуу зүдүү байдалд төрдөг.

Хүн бүр хүртсэн сайн эсвэл муу кармагаа зайлшгүй эдэлж туулах ёстой. Эдэлж туулаагүй карма 10 сая зууны туршид ч алга болдоггүй, байсаар л байдаг.

Тэгэхээр юу хийх вэ? Яах ёстой вэ?

Шримад Бхагаватамд Аджамали нэртэй нэгэн брахманы түүхийг өгүүлдэг. Тэрээр нэгэн янхантай гэрлэсэн бөгөөд 88 настай байхад нь Нараян нэртэй хүү төрдөг. Аджамали маш их хөгширсөн байлаа. Ямараджа хэзээ л бол хэзээ ирэн түүнийг авч явахаар байв. Гэнэт тэрээр урьд өмнө харж байгаагүй тийм аймшигтай байдлыг харсан. Хачин жигтэй хүмүүс ирээд түүнийг уяа цалмаараа оосорлон чирч татан гаргаж эхэлсэн. Тэр тэднээс маш их айсан. Тэр бие махбодио ч олигтойхон байлгаж барьж чадахааргүйгээр тэгж их айж байв. Тэгээд тэр хүүгээ “Нараян!, Нараян!” хэмээн дуудсан. Ингэхэд нь, бурханлаг ертөнцөд Вайкунтха гариг дээрээ залран байх Нараяана (Бурханы нэр) Өөрийг нь нэрээр нь дуудахыг сонсоод тэр даруйдаа хэд хэдэн вишнудута нарыг Канпура-гаас холгүй орших Каннодж тийш илгээсэн. Ингээд вишнудута болон ямадута нарын хооронд маш халуун яриа өрнөсөн. Вишнудута нар: “Цаашаа холдоцгоо.” гэж хэлэхэд ямадута нар түүнийг ямар гэм нүгэлтэй болохыг нь нэгд нэгэнгүй тоочин хэлдэг. “Бид нар үүргээ л биелүүлж байна.” гэж тэд хэлдэг. Вишнудута нар хариуд нь: “Та нарын хэлж тоочиж байгаа бүхэн үнэн, зөв, гэхдээ та нар нэгэн зүйлийг хайхрахгүй байж болохгүй. Энэ бол Нараяана. Түүний амнаас “Нараяана” гэдэг үг урсан гарсан. Иймээс тэр одоо нүглээсээ ариуссан.”

Гэхдээ энэ тухай сонсоод, амьдралдаа бурханлаг зүйл огтхон ч хийж үйлдэлгүйгээр, хөвгүүдээ Бурханы

нэрээр зүгээр л нэрлэж болно гэж бодох хэрэггүй. Харин нойрмог байдлаасаа сэрэн ХАРЕ КРИШНА ХАРЕ КРИШНА КРИШНА КРИШНА ХАРЕ ХАРЕ/ХАРЕ РАМА ХАРЕ РАМА РАМА РАМА ХАРЕ ХАРЕ мантра буюу Бурханы ариун гэгээн нэрийг давтан унших үйлийг үйлдэн дахин төрөхүйн энэхүү үйл явцаас салан ангижрахын төлөөх алхамуудыг хийцгээ!

www.vyasa.ru-гаас орчуулсан Чандра Бхавана даса.